ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ТӨРИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙГЭЭС БАТЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА

2018 оны 6 дугаар сар

Концессын зүйлийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс төслүүдийн хэрэгжилт хангалтгүй

Концессын төслүүдийн 76.4 хувийг"барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байгаа нь олон улсад барималж буй нийтлэг хандлагаас зөрүүтэй.

Концессын зүйлийг хэрэгжүүлснээр бий болох эдийн засаг, нийгмийн үр ашгийг тооцоогүй байна

Улаанбаатар
2018

АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Даваанням

Аудитын менежер: Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор: Б.Саруул

Аудиторууд: Б.Анхбаатар, Б.Хишигтогтох, М.Туул, М.Наранжаргал, Х.Энх-Амгалан

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын болон нийслэл, 12 аймаг дахь төрийн аудитын газрын аудиторууд оролцов.

2018 оны 6 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 261675, 261805 дугаарын утсаар харилцана уу.

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.
www.audit.mn

Хаяг:
Улаанбаатар 15160, Бага тойруу 6, Засгийн газрын IY байр

Монгол Улс

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 4
Аудитад ашигласан шалгуур 5
Товчилсон үгийн тайлбар 6
Үндсэн мэдээлэл 7

Бүлэг 1. Концессын зүйлийг хэрэгжүүлэх эрх зүйн харилцаа бүрэн зохицуулагдаагүй байна

- Концессыг хэрэгжүүлэхэд шаардагдах журам, аргачлал бүрэн батлагдаагүй, зарим журам боловсронгуй бус байгаа нь бодлого зохицуулалт хангалтгүйтэй холбоотой байна 9
- Концессын асуудал хариуцсан төрийн байгууллага тогтвортой ажиллаж ирээгүйгээс чиг үүргийг хэрэгжүүлэх боловсон хүчин мэргэшиж, чадавхжих боломж алдагдсан байна 10
- Концессын зүйлийн талаар улсын хэмжээний нэгдсэн мэдээллийн сан, бүртгэл хөтлөөгүй, концессын зүйлийн гүйцэтгэлийг зохистой хянаж, баталгаажуулахгүйгээс Засгийн газрын дотоод өрд концессын мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байна 11
- Концессын зүйлийн жагсаалтыг боловсруулж, батлахдаа холбогдох тооцоолол, судалгааг хангалтгүй хийж иржээ 13
- Концессын "барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээний эргэн төлөлтийн хуваарийг төсвийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдуулахгүй байна 14
- Концессын зүйлийн өртөг улсын төсвөөр баригдсан ижил хүчин чадалтай барилга, байгууламжийн төсөвт өртгөөс дунджаар 94.8 хувиар өндөр байна 15

Бүлэг 2. Батлагдсан төслүүдийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг тодорхойлоогүй байна

- Засгийн газар салбар хариуцсан яамдаас санал өгөөгүй төслүүдийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэснээс урьдчилсан судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээ жагсаалтад батлагджээ 18
- Концессын зүйлийг хэрэгжүүлэх хугацаа, стратегийг тодорхой болгож, жагсаалтыг шинэчлэн батлах шаардлагатай байна 19
- Концесс эзэмшигчийг сонгох аргыг тодорхойлох, шалгаруулалт явуулахдаа холбогдох хууль, журмыг зөрчсөн байна 20
- Концессын зарим төсөл эдийн засгийн хувьд үр ашигтай байх боловч төрийн дэмжлэг, зохицуулалт дутагдалтай байгаагаас хэрэгжилт хангалтгүй байна 23
- Концессын гэрээгээр бодлогын зорилттой нийцэхгүй, хууль зөрчсөн, үр ашиггүй хөрөнгө оруулалт хийж байна 24
- Нийт концессын 74.6 хувийг "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байгаа нь олон улсын нийтлэг хандлагаас зөрүүтэй байна 25
- Хяналтын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль зөрчсөн байна 26

Бүлэг 3. Концессын зүйлийн хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавиагүй, үр нөлөө хангалтгүй байна

- Концессын зүйлийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гаргасан Засгийн газрын шийдвэрүүд уялдаа холбоогүй, холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын хяналт хангалтгүй байна 28
- Салбарын яам концесс олгогч, концесс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр төслийн нэгжийг байгуулж, үргүй зардал гаргажээ 32
- Концесс эзэмшигчид хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэхэд хугацаа алдаж байгаа нь төслүүд хугацаандаа хэрэгжихгүй байх шалтгаан болж байна 33
- Гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг зөвхөн барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй уялдуулж байгаа нь эрсдэлтэй байна 34

- Барилга байгууламжийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаатай холбоотой үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаагүйгээс ашиглагч байгууллагын хэрэгцээг бүрэн хангахгүй байна 35
- Ашиглалтад орсон концессын зүйлүүдийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг бүрэн тодорхойлоогүй байна 35

Аудитын дүгнэлт: 37
Аудитын зөвлөмж ба санал болгох зүйлс: 38
Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн санал: 39
Саналд өгсөн тайлбар: 40
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал:..... 41

Хавсралтууд:
Хавсралт №1. Төрийн өмчийн гэрээ байгуулагдсан концессын зүйлийн жагсаалт 43
Хавсралт №2. Концессын зарим зүйлийн гэрээний үнийн судалгаа 48
Хавсралт №3. Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа арга хэмжээнд олгосон санхүүжилтийн судалгаа 49
Хавсралт №4. Зарим улс орны ТХХТ-ийн тогтолцоонд хийсэн харьцуулсан судалгаа 50

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан ҮАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн.

- Концессыг хэрэгжүүлэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалт хангалттай бүрдсэн эсэх,
- Концессын зүйлийн жагсаалтад батлагдсан арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх,
- Концессын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

Хамрах хүрээ:

Аудитыг 2017 оны 8 дугаар сарын байдлаар гэрээ байгуулагдсан[1] төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээний хүрээнд Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага, концесс эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдийг хамруулан гүйцэтгэв.

Аудитын явцад хууль, хяналтын байгууллагаар шалгагдаж буй “Төрийн тусгай хамгаалалтын газарт материал илрүүлэгч төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн хэрэгжилттэй холбоотой баримт шалгагдагч байгууллагуудад байхгүй байсан тул аудитад хамруулаагүй болно.

Мөн Засгийн газрын 2015 оны 49 дүгээр тогтоолоор гэрээ байгуулах эрх олгосон “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор төсөл”-ийн “Рич голден буллс эдүкэшн” ХХК-тай байгуулсан гэрээг Засгийн газрын 2015 оны 354 дүгээр тогтоолоор цуцалж, “Топ инженеринг Монголиа” ХХК-тай байгуулсан нь шүүхээр хянагдаж байсан, Засгийн газрын 2013 оны 399 дүгээр тогтоолоор гэрээ байгуулах эрх олгосон “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны автозам төсөл”-ийн “Чингис Лэнд Девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” ХХК-тай байгуулсан концессын “барих-ашиглах-шилжүүлэх“ гэрээг Засгийн газрын 2015 оны 158 дугаар тогтоолоор цуцалж, шүүхээс уг тогтоолыг хүчингүй болгосон, төслүүдийн материалыг Үндэсний хөгжлийн газраас гаргаж өгөөгүй тул аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам болон удирдамж (АДБОУС 300, 3000-3100)-ийг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ингэхдээ ТХХТ-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрхийн актыг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, судалгаа, тайлан зэрэг баримт,

[1] Гэрээ байгуулагдсан төрийн өмчийн концессын зүйлийн төсөл, арга хэмжээний талаарх Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан аудитын хамрах хүрээ тодорхойлогдсон болно. Аудитын төлөвлөлтийн шатанд урьдчилсан судалгаа гаргуулах үед ирүүлсэн концессын зүйлийн жагсаалт, мэдээллээ Үндэсний хөгжлийн газар нь аудит эхэлсний дараа хэд хэдэн удаа өөрчилсөн нь аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх боломжийг алдагдуулж, аудитын хамрах хүрээ бодитой тогтоогдохгүй байх эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

	мэдээлэлд дүн шинжилгээ, тулган баталгаажуулалт хийхийн зэрэгцээ барилга, байгууламжууд холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу баригдсан эсэх талаар хөндлөнгийн шинжээчидтэй хамтран ажиллалаа. Түүнчлэн, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын дагуу концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд ҮАГ-аас гаргаж байгаа дүгнэлтийн үр дүнг энэхүү аудитын тайланд зохих байдлаар уялдуулан тусгахад чиглэсэн болно.
Хүндрэл, бэрхшээл	Концессын асуудал хариуцсан төрийн байгууллагууд тогтвортой ажиллаагүй, концессын төслийн санал боловсруулалт, зардал, ашгийн тооцоолол, сонгон шалгаруулалттай холбоотой баримт, мэдээллийн бүрдэл хангалтгүй, нэгдсэн мэдээллийн сан байгуулаагүй байсан нь аудитын нотлох баримт бүрдүүлэхэд болон аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхэд цаг хугацаа алдах, мөн төлөвлөгдөөгүй нэмэлт горим гүйцэтгэх зэргээс шалтгаалан хүндрэл, бэрхшээл гарч, хугацаа сунгагдсан болно.
Аудитад ашигласан шалгуур:	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ. ▪ Концессын тухай хууль, ▪ Монгол Улсын 2016, 2017 оны Төсвийн тухай хууль болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд, ▪ Төсвийн тухай хууль, ▪ Өрийн удирдлагын тухай хууль, ▪ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ▪ Авто замын тухай хууль, ▪ Барилгын тухай хууль, ▪ Иргэний хууль, ▪ Компанийн тухай хууль, ▪ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, ▪ Төрөөс төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг, ▪ Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Концессын зүйлийн жагсаалт”, түүнд оруулсан өөрчлөлтүүд, ▪ Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Концессын зүйлийн жагсаалт”, түүнд оруулсан өөрчлөлтүүд, ▪ Дээрх хууль, шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад хууль, эрхийн актууд.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУВС	Олон Улсын валютын сан
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНбД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХОГ	Хөрөнгө оруулалтын газар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

ГАДААД ҮГИЙН ТАЙЛБАР

PIMAC	Public infractructure investment management center буюу Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын газар
DMFAS	Debt Management and Financial Analysis System буюу Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем
ASEM	Asia-Europe-Meeting буюу Ази, Европын орнуудыг нэгтгэсэн олон улсын байгууллагын уулзалт

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
1	Концессын хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний судалгаа	8
2	Концессын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын судалгаа	11
3	Төрийн өмчийн концессын “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулсан гэрээний эргэн төлөлтийн хуваарийг улсын төсвийн төлөвлөлттэй харьцуулсан судалгаа	14
4	Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулсан гэрээний эргэн төлөлтийг улсын төсвийн хөрөнгийн зардалтай харьцуулсан судалгаа	15
5	Өртгийн харьцуулсан судалгаа	15
6	Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын нэмэлт зардлын судалгаа	16
7	Төрийн өмчийн концессын зүйлийн төсөл, арга хэмжээний тооны өөрчлөлтийн судалгаа	18
8	Концессын гэрээний хэрэгжих хугацаа	26

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Дүрслэлийн нэр	Хуудас
1	Гэрээ байгуулсан концессын зүйлийн салбарт эзлэх хувь	8
2	Концессын зүйлийн батлагдсан болон гэрээ байгуулсан төслийн тоо	19
3	Концесс эзэмшигчийг сонгох хэлбэр, салбарын ангиллаар	20

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болгох зорилгоор УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор "*Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого*"-ыг баталсан. Бодлогын 1.2-т төр, хувийн хэвшлийн түншлэлийн ерөнхий зарчмыг "... *бодлого нь дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх, Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлийн этгээдээр гүйцэтгүүлэх замаар төрийн оролцоог оновчтой болгох, суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ*" гэж тодорхойлсон байна.

Бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор 2010 онд Концессын тухай хуулийг баталсан бөгөөд хуулийн 3.1.1-д *концессыг* **"***төрийн эсхүл орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах* ***"онцгой эрх"*** гэж тодорхойлжээ.

Концесс эзэмшигч концессын зүйлийг ***өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр*** барьж ашиглалтад оруулан дор дурдсан төрлөөс аль нөхцөлөөр гэрээ байгуулснаас шалтгаалан тодорхой хугацааны дараа хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэхээр хуульд тусгагдсан байна. Үүнд:

4.1.1-т "Барих-ашиглах-шилжүүлэх" гэрээнд заасан хугацаанд барьж, ашиглах,

4.1.2-т "Барих-шилжүүлэх"гэрээнд заасан хугацаанд барьж, шууд төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх,

4.1.3-т "Барих-өмчлөх-ашиглах" гэрээнд заасан нөхцөлөөр өмчлөх, ашиглах эрх эдэлж, үүрэг хүлээх,

4.1.4-т "Барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх" гэрээнд заасан хугацаанд өмчлөн ашиглах,

4.1.5-д "Барих-түрээслэх-шилжүүлэх" гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх бүхий этгээдэд санхүүгийн түрээсээр эзэмшүүлэх, түрээсийн хугацаа дуусгавар болоход шилжүүлэх,

4.1.6-д "Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах" гэрээнд заасан хугацаанд ашиглах,

4.1.7-д "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээнд заасан нөхцөлөөр концессын зүйлийг шинэчлэн сайжруулсан зүйлийн хамт шилжүүлэх.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн 125 төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг баталсан байна. Концессын тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг 2012 онд Төрийн өмчийн хорооноос ЭЗХЯ (хуучин нэрээр)-нд шилжсэнтэй холбогдуулан Засгийн газар дээрх тогтоолыг хүчингүй болгож, 2013 оны 317 дугаар тогтоолоор концессын зүйлийн 53 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 148 арга хэмжээ бүхий төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг шинээр баталжээ.

Жагсаалтад 2014 оноос 2017 оны эхний 9 сарыг дуусталх хугацаанд нийт 29 удаагийн тогтоолоор 115 арга хэмжээг нэмж, 5 удаагийн тогтоолоор 22 арга хэмжээг хасаж, 15 тогтоолоор 115 арга хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, нийт 242 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант хугацаанд концессын 57 зүйлийн гэрээ байгуулагдсанаас 2017 оныг дуусталх хугацаанд 25 гэрээний хэрэгжилт хангагдаж:

- 4600 суудалтай ерөнхий боловсролын сургууль 4, 1300 ортой хүүхдийн цэцэрлэг 6,
- 282.2 км хатуу хучилттай авто зам, 43.2 км хүнд даацын авто зам, 72.85 уртааш метр төмөр бетон гүүр, 90 метр хөвдөг гүүр, 400 автомашины зогсоол,
- 50 км 110 кВт-ын ЦДАШ, дэд станц,
- 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминал болон цэвэр усны шугам зэрэг бүтээн байгуулалтын төслүүд ашиглалтад орсон байна.

ОУВС-тай байгуулсан өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд гаргасан тайланд[2] Монгол Улсын ТХХТ-ийн явцыг "**муу**" гэж үнэлсэн бөгөөд эрх зүйн орчны хөгжил сул, Засгийн газрын оролцоо ихтэй, Сангийн яамны оролцоо бага, ихэнх төслийг "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж эхэлсэн, концессын зүйлийг хэрэгжүүлэх нийтэд мэдээлсэн тодорхой стратеги, оролцогчийг сонгох шалгуур тогтоогоогүй, төслүүдийн өртөг нь төсвийн санхүүжилттэй ижил төрлийн төслүүдээс 25-30 хувиар өндөр, ТХХТ-ийг хэрэгжүүлэхдээ мөнгөний үнэ цэнийг харгалздаггүй буюу ТЭЗҮ боловсруулагдаагүй, зардал, ашгийн тооцоолол хийгдээгүй төслүүдийг хэрэгжүүлдэг гэж дүгнэсэн байна.

Төрийн өмчийн концессын 71.9 хувь буюу 174 арга хэмжээг "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр баталж, гэрээ байгуулсан 57 концессын зүйлийн 75.0 хувь буюу 42 арга хэмжээ "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа нь олон улсад "барих-ашиглах-шилжүүлэх" төрөл нийтлэг хэрэглэгддэг арга, туршлагаас ихээхэн ялгаатай байна.

Хүснэгт 1. Концессын хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний судалгаа (тоо, тэрбум төгрөг)

№	Концессын төрөл	Концессын зүйлийн жагсаалтад батлагдсан		Гэрээ байгуулсан		Ашиглалтад орсон	
		ТАХ-ний тоо	Эзлэх хувь	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Гэрээний дүн
1	Барих-шилжүүлэх	174	71.9	42	2,627.7	23	824.2
2	Барих-ашиглах-шилжүүлэх	34	14	9	9,953.4	1	109.0
3	Барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх	2	0.8	4	3,956.2	-	
4	Барих-өмчлөх-ашиглах	23	9.5				
5	Барих-түрээслэх-шилжүүлэх	2	0.8				
6	Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх	6	2.5	1	700.0		
7	Нийлүүлэх-суурилуулах-шилжүүлэх	1	0.4	1	2.6	1	2.6
НИЙТ		242	100	57	17,239.9	25	935.8

Эх сурвалж: ҮАГ

Дүрслэл 1. Гэрээ байгуулсан концессын зүйл, салбарын ангиллаар /хувь/

Төрийн өмчийн концессын зүйлд гэрээ байгуулагдсан 57 зүйлээс боловсролын салбарт 75.2 тэрбум төгрөгийн 18 сургууль, цэцэрлэг, 307.0 тэрбум төгрөгийн соёлын төв, музей барих 2, байгаа бол авто замын салбарт 1,656.3 тэрбум төгрөгийн 16 зам, гүүрний ажил, 3,455.6 тэрбум төгрөгийн 2 төмөр зам, терминал, эрчим хүчний салбарт 11,430.4 тэрбум төгрөгийн 11 эрчим хүчний дэд станц, шугам, 165.5 тэрбум төгрөгийн 4 дэд бүтцийн шугам, эрүүл мэндийн салбарт 25.7 тэрбум төгрөгийн эмнэлгийн 1 барилга, харин 2.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулах 1 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр байна. */Дэлгэрэнгүйг хавсралт 1-д үзүүлэв./*

[2] Эх сурвалж: Technical Assistance report 2016. IMF, хуудас 26

БҮЛЭГ 1. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА БҮРЭН ЗОХИЦУУЛАГДААГҮЙ БАЙНА

Концессыг хэрэгжүүлэхэд шаардагдах журам, аргачлал бүрэн батлагдаагүй, зарим журам боловсронгуй бус байгаа нь бодлого зохицуулалт хангалтгүйтэй холбоотой байна

1.1 УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогыг баталсантай холбогдуулан УИХ-аас Засгийн газарт даалгасан үүрэг, ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын дараах зорилт, арга хэмжээ өнөөг хүртэл хэрэгжээгүй байна. Үүнд:

- *УИХ-ын 64 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 2.1-ийн "ТХХТ-ийн талаар Төрөөс баримтлах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2010 оны нэгдүгээр улиралд багтаан батлах",*
- *ТХХТ-ийн талаар Төрөөс баримтлах бодлогын 6 дугаар бүлгийн 6.1.3-ын "төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн байдалд мониторинг, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг батлах" зэрэг болно.*

1.2 Концессын асуудал эрхэлсэн ҮХГ нь концессын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжүүлэхэд хэрэглэгдэх, гэрээний нөхцөлд зайлшгүй тусгах шаардлагатай Концессын тухай хуульд заасан дараах 5 журам, 1 аргачлалыг боловсруулж, батлуулах байтал өнөөг хүртэл боловсруулаагүй, хууль хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- *Концессын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.1.16: "концессын гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө концессын зүйлийг эзэмших, ашиглах, түүнчлэн түүнийг ашиглан ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдон үүссэн өр төлбөр, авлага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын, эсхүл төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хүлээсэн үүрэг, хариуцлага, тэдгээрийг шийдвэрлэх журам",*
- *Концессын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.1.18:"өндөр өртөгтэй эсхүл сонирхлын зөрчилтэй хэлэлцээр хийх, түүнд төрийн эрх бүхий байгууллагаас хяналт тавих журам",*
- *Концессын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.1.20: "концессын зүйлийг шалгах, турших, хүлээж авах, зөвшөөрөл олгох, концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих, концессын зүйлийг шилжүүлснээр түүнийг ашиглах технологийг шилжүүлэх, ажилтныг сургах журам",*
- *Концессын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.1.23: "концессын гэрээний хугацаа, түүнийг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, концессын гэрээ ба холбогдох бусад гэрээний хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол ба гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, концессын зүйлийг хүлээлгэн өгөх ба шилжүүлэх арга хэмжээ, маргаан шийдвэрлэх журам",*
- *Концессын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.1.3: "концессын зүйлийг ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний төлөө концесс эзэмшигчийн төлбөр авах эрх, үнэ, төлбөр тогтоох, өөрчлөх аргачлал",*
- *Концессын тухай хуулийн 6 дугаар бүлгийн 28 дугаар зүйлийн 28.2.1: "концесс эзэмшигчийг өөрчлөх нөхцөл, журам"-ыг тус тус боловсруулаагүй байна.*

1.3 Дээр дурдагдсан журмыг "з*аавал батлуулахаар хуульд заагаагүй, зохион байгуулалтын бүтэц тогтвортой ажиллаагүй"* гэсэн шалтгаанаар баталж, үйл ажиллагаандаа мөрдөөгүйгээс "барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр байгуулсан "Дулааны 5 дугаар цахилаан станц барих", "Туул сонгино усны нөөцийн цогцолбор" зэрэг томоохон төслүүдийн хэрэгжилт удааширсан, "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулагдсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, бүрэн дуусаагүй барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан зөрчил гарч байна.

1.4 Түүнчлэн өмнө гарсан болон түр мөрдөх зарим журам, аргачлалыг Концессын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн, сайжруулаагүй байна. Үүнд:

- *Концессын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 11.4: "Уралдаант шалгаруулалтын нарийвчилсан журам, жишиг баримт бичиг, санал үнэлэх журмыг Засгийн газар батална" гэж заасны дагуу Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор "Концесс олгох уралдаант шалгаруулалт явуулах журам", "Концесс олгох уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам", "Урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг", "Уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг" зэргийг баталсан боловч хуульд заасан шаардлагад нийцүүлэн эдгээр журамд өөрчлөлт,*

сайжруулалт хийгээгүйгээс 2013-2017 онд зохион байгуулсан уралдаант шалгаруулалтын 60.0 хувь нь амжилтгүй болж, шууд гэрээ байгуулах аргыг сонгосон, зарим тохиолдолд шууд гэрээ байгуулах хэлэлцээрийг хийх байгууллагыг хэрхэн сонгосон талаар ажлын баримт материал байхгүй байна. Тухайлбал, Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т "... дахин зарласан ч шаардлагатай хугацаанд санал ирэх магадлал бага гэж эрх бүхий этгээд үзсэн", "Концесс олгох шалгаруулалтын санал үнэлэх журам"-ын 5.15.1[3] -д "ерөнхий шаардлагыг хангасан оролцогч байгаагүй" гэсэн заалтууд нь хэтэрхий ерөнхий агуулгатай байх бөгөөд эдгээр заалтыг үндэслэн шууд гэрээ байгуулах нарийвчилсан зохицуулалтгүй байна.

- *Концессын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.8-д "Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх аргачлалыг батална" гэж заасны дагуу Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолоор "Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал"-ыг мөрдсөн боловч хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөлт, сайжруулалт хийгээгүйгээс тус аргачлал нь "барих-шилжүүлэх" концессын зүйлийн хувьд ашиглагдах боломжгүй байна.*

1.5 Төсвийн тухай хууль, тогтоомжид заасан дараах аргачлал, маягтыг Сангийн яам өнөөг хүртэл боловсруулаагүй байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 11-д заасны дагуу "Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлал",*
- *Засгийн газрын 2010 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах журам"-ын 2.7[4] -д заасан "... хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах, үнэлэх, санхүүжүүлэх, тайлагнах, хяналт тавих, дүгнэх аргачлал, заавар маягт".*

1.6 Холбогдох хууль, тогтоомжид тусгайлан заагаагүй боловч, концессын харилцааг зохицуулсан дараах журам, зохицуулалтыг зайлшгүй боловсруулж, мөрдөх шаардлагатай байна. Үүнд:

- *Концессын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д "концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" гэж заасны дагуу концессын гэрээнд үнэлгээ хийх, хяналт тавих харилцааг зохицуулсан журам,*
- *Концессын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Концессын гэрээний хэрэгжилтэд концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллага, тухайн концессын зүйлийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хуульд заасан хяналт тавих эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавина" гэж заасны дагуу концессын зүйлийн хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт тавих журам.*

1.7 ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын болон Төсвийн тухай хуульд заасан */тайлангийн 1.2, 1.4, 1.5-д дурдсан/* зайлшгүй шаардлагатай журам, аргачлалуудыг өнөөг хүртэл боловсруулаагүй, шинэчлэн сайжруулаагүй байгаа нь концессын зүйлийн төлөвлөлт, хэрэгжилтээс гарах аливаа эрсдэлийг удирдахад хүндрэл үүсгэхийн зэрэгцээ холбогдох талуудын хүлээх үүрэг, хариуцлагын болон тэдгээрт тавих үр нөлөөтэй хяналтын тогтолцоо бүрдэхгүй, төрийн байгууллагууд харилцан уялдаатай, хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж хангагдахгүй, хязгаарлагдмал нөхцөлийг үүсгэж байна.

Концессын асуудал хариуцсан төрийн байгууллага тогтвортой ажиллаж ирээгүйгээс чиг үүргийг хэрэгжүүлэх боловсон хүчин мэргэшиж, чадавхжих боломж алдагдсан байна

1.8 Концессын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд ТХХТ, концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэр, зохион байгуулалтын бүтэц, харьяалал сүүлийн 7 жилийн хугацаанд 5 удаа өөрчлөгджээ.

Хүснэгт 2. Концессын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын судалгаа

№	Байгууллагын нэр	Тухайн байгууллага дахь нэгжийн нэр	Хугацаа	Мэргэжилтний тоо
1	Төрийн өмчийн хороо	Концесс, ТХХТ-ийн газар	2010.03.01-ээс 2012.09.29 хүртэл 2 жил 6 сар	8

[3] Монгол Улсын аль нэг арилжааны банканд дахь өөрийн нэр дээрх дансанд тухайн төсөлд өөрийн санал болгож буй нийт хөрөнгө оруулалтын 1/4-ээс доошгүй хувьтай тэнцэх төгрөг эсхүл гадаад валютыг байршуулсан тухай нотлох баримт

[4] "... Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах, үнэлэх, санхүүжүүлэх, тайлагнах, хяналт тавих, дүгнэх аргачлал, заавар маягтыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо холбогдох яам, эрх бүхий байгууллагатай хамтарч батлан мөрдүүлнэ"

2	Эдийн засгийн хөгжлийн яам	Концесс, ТХХТ-ийн хэлтэс	2012.09.29-өөс 2014.10.15 хүртэл 2 жил 1 сар	15
3	Сангийн яам	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	2014.10.16-аас 2014.12.04 хүртэл 2 сар	-
4	Хөрөнгө оруулалтын газар	Концесс, ТХХТ-ийн хэлтэс	2015.01.05-аас 2016.07.27 хүртэл 1 жил 6 сар	8
5	Үндэсний хөгжлийн газар	Концесс, ТХХТ-ийн алба	2016.08.12-ноос өнөөг хүртэл	5

Эх сурвалж: ҮАГ

1.9 ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогод хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар байгаа боловч одоогийн бүтцээр Концессын тухай хуулийн 3.1.7[5]-д заасны дагуу төрийн өмчийн концессын зүйлийн хувьд ҮХГ, орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлэхээр байна.

1.10 ЭЗХЯ (хуучин нэрээр) болон ХОГ (хуучин нэрээр) байх үед концессын асуудлыг хариуцсан нэгж нь 8-12 ажилтны орон тоотой ажиллаж байсан бол ҮХГ-ын хувьд 5 орон тоотой ажиллаж байгаа нь хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн тоо өмнөх үеийнхээс нэмэгдсэнтэй харьцуулахад орон тооны хүрэлцээ буурсан, ажлын ачаалал ихэссэн байна.

1.11 Ийнхүү концессын зүйлийг хэрэгжүүлж, хяналт тавих эрх бүхий байгууллага болон түүний бүтэц, зохион байгуулалт, хариуцсан нэгж тогтворгүй ажиллаж ирсэн нь мэргэшсэн боловсон хүчингүй болж, боловсон хүчнийг чадавхжуулах нөхцөл боломжийг алдагдуулж иржээ.

Концессын зүйлийн талаар улсын хэмжээний нэгдсэн мэдээллийн сан бүртгэл хөтлөөгүй, концессын зүйлийн гүйцэтгэлийг зохистой хянаж, үнэлдэггүйгээс Засгийн газрын дотоод өрд концессын мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байна

1.12 Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд[6] концессын төслүүдийн талаар улсын хэмжээний иж бүрэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлээгүй, зөвхөн өөр өөрийн цахим сайтад концессын зүйлийн жагсаалт, концесс олгох уралдаант шалгаруулалтын урилгыг нийтлэх, холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг болон концессын зарим гэрээг байршуулах төдийгөөр хязгаарлаж байгаа нь Концессын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 6.2.9[7], наймдугаар бүлгийн 33 дугаар зүйлийн 33.4[8]-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.13 Концесс эзэмшигчийн сонгон шалгаруулалт, концесс эзэмшигчийн танилцуулга, концессын гэрээний хэрэгжилт, үр дүн зэрэг тухайн концессын зүйлийн талаарх ач холбогдолтой мэдээллийг олон нийтэд хүргээгүй байна.

1.14 Энэ нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасан *"... мэдээллээр хангах үйл ажиллагаа шуурхай байх*" гэсэн зарчимтай нийцэхгүй, мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх ажиллагаа хийгдэхгүй байна.

1.15 ҮХГ концессын зүйлийн талаар нэгдсэн бүртгэл хөтлөөгүй, мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас ТХХТ, концессын зүйлийн талаар иргэд, олон нийтийн ойлголт хангалтгүй[9] байна.

1.16 Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7-д[10] заасны дагуу "DMFAS" программд өрийг бүртгэхдээ Сангийн яам концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж

[5] "эрх бүхий этгээд" гэж төрийн өмчийн концессын зүйлийн хувьд концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг, орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд аймаг, нийслэлийн Засаг даргыг

[6] Төрийн өмчийн хороо, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Аж үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар

[7] концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд концессын талаарх нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх

[8] эрх бүхий этгээд уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа баримт бичиг, материалыг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж хадгална.

[9] Удирдлагын академи "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сорилт, боломж 2017" судалгааны тайлан, 73 дугаар хуудас, Төслийн оролцогч тал, олон нийттэй холбоотой бэрхшээл

[10] Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ.

байгаа төслүүдийн хувьд ҮХГ-аас ирүүлсэн концессын төслүүдийн барилга, угсралтын ажлын гүйцэтгэлийн хувиар тооцсон "*Улсын төсвөөс эргэн төлөх концессын төслийн гүйцэтгэлийн мэдээ*"-нд үндэслэн[11] гаргаж иржээ.

1.17 Засгийн газрын дотоод өрийн бүртгэлд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төрийн өмчийн 40 концессын зүйл бүртгэлтэй байгаагаас 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжиж дуусан боловч өрийн үлдэгдэлтэй 16 төслийн 372.0 тэрбум, хэрэгжиж буй 10 төслийн 378.9 тэрбум, нийт 26 төслийн 750.9 тэрбум төгрөгийн өр бүртгэлтэй байна.

1.18 ҮХГ нь концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг үнэн зөв тогтоож чадахгүй байгаагаас шалтгаалан Засгийн газрын өр бодитой илэрхийлэгдэхгүй байна. Тухайлбал,

- ***Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл:*** *ЗТХЯ-ны ТНбД-ын 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 164 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг уг авто замын ажлын тоо хэмжээг тодорхойлж, нийт гүйцэтгэсэн ажлын зардал нь 1,431.8 сая төгрөг гэж тогтоосноос хойш шүүхийн асуудлаас шалтгаалан тус авто замын ажил огт үргэлжлээгүй байхад ҮХГ-аас Сангийн яаманд 2017 оны жилийн эцэст ажлын явцыг 5 хувь гэж мэдээлсний улмаас Засгийн газрын дотоод өрд 9,340.0 сая төгрөгөөр буюу бодит гүйцэтгэлээс 7,908.2 сая төгрөгөөр илүү бүртгэгдсэн.*
- ***Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл:*** *концессын гэрээ хүчин төгөлдөр болоогүй, ажлын гүйцэтгэл гаргаж баталгаажуулаагүй байхад ҮХГ-аас ажлын гүйцэтгэлийг 2017 оны 2 болон 3 дугаар улиралд 15 хувьтай, 4 дүгээр улиралд 23 хувьтай гэж мэдээлсний улмаас 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын дотоод өрд 37,908.4 сая төгрөгөөр илүү бүртгэгдсэн.*
- ***Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих төсөл:*** *Уг ажлын эхний ээлжийн 25 км авто замын барилгын ажлыг улсын комисс 2016 онд хүлээн авсан ба энэ нь нийт ажлын 26.3 хувь болж байхад тухайн оны эцэст 57,163.9 сая төгрөг буюу нийт ажлын 70.3 хувийн санхүүжилтийг олгож, холбогдох дүнгээр өрд бүртгэжээ. Харин жилийн дараа буюу 2017 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар тус авто замын ажлын нийт гүйцэтгэл 70.5 хувьтай болсон байна. Өөрөөр хэлбэл, тус шалтгааны улмаас 2016 оны Засгийн газрын дотоод өрд 21,324.9 сая төгрөгөөр илүү бүртгэгджээ.*
- ***Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл:*** *ҮХГ-аас гэрээ хүчин төгөлдөр болоогүй, ажил эхлээгүй байхад ажлын гүйцэтгэлийг 2017 оны эхний хагас жил болон гуравдугаар улиралд 15 хувь гэж Сангийн яаманд тайлагнасан бөгөөд 2017 оны жилийн эцэст залруулга хийж 1 хувьтай гэж мэдээлснээр 871.9 сая төгрөгийг өрд бүртгэсэн. (Гэрээ хүчин төгөлдөр болгох дүгнэлт 2017 оны 11 дүгээр сарын 30-нд гарсан байна.)*

1.19 Цаашид ҮХГ-аас концессын төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, мэдээлэх үйл ажиллагаа, тогтолцоог сайжруулах замаар Засгийн газрын өрийн мэдээллийг бодитой бүртгэж, тайлагнах шаардлагатай байна.

Концессын зүйлийн жагсаалтыг боловсруулж, батлахдаа холбогдох тооцоолол, судалгааг хангалтгүй хийж иржээ

1.20 Засгийн газрын 2012 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан "*Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр*" (цаашид "хөтөлбөр" гэх)-т ТХХТ-ийн хүрээнд 33 арга хэмжээнд 36,037.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад дээрх хөтөлбөрт тусгагдаагүй, судлагдаагүй төслүүдийг баталсан нь Төсвийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 28 дугаар зүйлийн 28.10[12], Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1[13] дэх заалт зөрчигдсөн, Төсвийн

[11] Концессын тухай хуулийн 6.2.13-т "холбогдох журмын дагуу концесс эзэмшигчээс концессын гэрээний ашиглалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг улирал бүр гаргуулан авч, нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх"

[12] Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, гадаад зээллэг, тусламж болон концессын гэрээ, Засгийн газрын өрийн баталгаа Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна.

[13] Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын төслийг боловсруулахтай холбогдсон харилцааг Төсвийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

тухай хуулийн 28 дугаар зүйлд[14] заасан хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал,

Засгийн газрын 2015 оны 306 дугаар тогтоол:
- *Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төсөл,*
- *Сэлэнгэ аймгийн Мандал сумын дулааны төв шугам, дулааны дэд станц, бохирын шугам барих ажил,*

Засгийн газрын 2016 оны 73, 74, 264, 273 дугаар тогтоолууд:
- *Сургууль, цэцэрлэгийн барилга барих (нэг маягийн зураг, төсөвтэй),*
- *Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам,*
- *Улаанбаатар хот, Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам,Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих,*

Засгийн газрын 2017 оны 26, 84 дүгээр тогтоолууд:
- *Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам,*
- *Дорноговь аймгийн Сайншанд сум болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам.*

1.21 Холбогдох төрийн захиргааны байгууллагууд Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4[15]-т заасныг зөрчиж ирснээс концессын төслүүдэд зардал, ашгийн тооцоо, судалгаа хийгдээгүй байна. Тухайлбал,

Авто зам, төмөр замын төсөл:
- *Хэнтий аймгийн Биндэр сумын Ононгийн гүүрийг шинэчлэх төсөл,*
- *Чойр-Сайншанд чиглэлийн замаас Бор-Өндөр хүртэлх 50 км хатуу хучилттай авто зам,*
- *Сонгино-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам,*
- *Тосонцэнгэлийн 4 замын уулзвар, Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам,*
- *Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр зам,*

Эрчим хүчний төсөл:
- *Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажил,*
- *Увс аймгийн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам барих,*
- *Тэлмэний дулааны цахилгаан станц,*

Нийгмийн хамгааллын төсөл:
- *Хүний хөгжлийн төв цогцолбор,*

Боловсролын төсөл:
- *БСШУСЯ-аас зардал, ашгийн тооцоолол хийгдээгүй, нэг маягийн зураг, төсөл бүхий сургууль, цэцэрлэгийн барилгын жагсаалтыг ҮХГ-т хүргүүлсэн бөгөөд концесс эзэмшигчид холболтын зураг боловсруулан магадлал хийлгэх ажлыг зохион байгуулж байна.*

1.22 Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо, судалгааг хийгээгүй, концессын гэрээ байгуулахад түүнийг харгалзах хүчин зүйл болгон авч үзэхгүй байгаагаас концессыг хэрэгжүүлэхэд гарах эрсдэл, хөрөнгө оруулалтын үүрэг хариуцлага, санхүүжилтийн нөхцөлийг харилцан үр ашигтай тогтоосон гэж үзэх боломжгүй байна. Тухайлбал,

- *Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Жаргалантын ам дахь хувийн хэвшлийн "Чингисийн хүрээ" жуулчны баазад нэг удаагийн буюу ASEM арга хэмжээнд зориулж, 400 автомашины зогсоол барих,*

1.23 Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "*Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал*"-аар "барих-шилжүүлэх" төрлөөр нийгмийн салбарт хэрэгжих төслүүдэд зардал, ашгийн тооцоо хийх боломжгүй байгаа тул тус аргачлалыг шинэчлэн боловсруулж, нийгмийн салбарын онцлогийг нэмж тусгах шаардлагатай байна.

---

[14] Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах ТАХ-ний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дараалыг дараах зүйлийг харгалзан тогтооно:

28.3.1.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого;
28.3.2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж;
28.3.3.нийгмийн ач холбогдол;
28.3.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл;
28.3.5.төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт;
28.3.6.салбарын хөгжлийн бодлого;
28.3.7.бүсчилсэн хөгжлийн бодлого;
28.3.8.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ;
28.3.9.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;
28.3.10.болзошгүй өр төлбөр болон санхүүгийн бусад эрсдэлийн үнэлгээ.
28.3.11.Өрийн удирдлагын тухай хууль болон Стратегийн баримт бичигт заасан шаардлага.

[15] Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

Концессын "барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээний эргэн төлөлтийн хуваарийг төсвийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдуулаагүй байна

1.24 Төрийн өмчийн концессын зүйлийн 42 гэрээг "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулан нийт 2,654.6 тэрбум төгрөгийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг тооцоолол хийж үзэхэд 2020 онд 551.9 тэрбум төгрөгөөр улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл хамгийн өндөр байна.

Хүснэгт 3. Төрийн өмчийн концессын "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан гэрээний эргэн төлөлтийн хуваарийг улсын төсвийн төлөвлөлттэй харьцуулсан судалгаа (сая төгрөгөөр)

Он	Гэрээний эргэн төлөлтийн хуваарь	Олгосон санхүүжилт	Төсвийн тухай хуулиар батлагдсан	Зөрүү илүү (-), дутуу (+)
2016 он	254,789.5		251,313.6	3,475.9
2017 он	418,971.8		177,711.6	241,260.2
2018 он	438,715.4		82,884.4	355,831.0
2019 он	336,759.2			336,759.2
2020 он	551,984.3			551,984.3
2021 он	369,625.1			369,625.1
2022 он	173,227.2			173,227.2
2023 он	23,267.0			23,267.0
2024 он	23,267.0			23,267.0
2025 он	23,267.0			23,267.0
2026 он	40,742.3			40,742.3
Дүн	2,654,615.8		511,909.6	2,142,706.2

Эх сурвалж: Концессын гэрээний дүнгээс

1.25 Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа нийт 2.7 их наяд төгрөгийн 42 төсөл, арга хэмжээний эргэн төлөлт нь улсын төсвөөс 2016 оноос эхлэн хийгдэж ирсэн. Монгол Улсын 2016 он, 2017 он болон 2018 оны Төсвийн тухай хуульд батлагдсан арга хэмжээний санхүүжилтийг концессын гэрээний эргэн төлөлттэй харьцуулахад 2.4-5.3 дахин бага хөрөнгийг концессын эргэн төлөлтөд олгохоор баталсан байна.

1.26 Концессын "барих-шилжүүлэх" гэрээний төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарьт 2017-2018 онуудад улсын төсвийн хөрөнгийн зардлын 44.9-59.8 хувийг эзэлж, 2019-2021 онуудад буюу дунд хугацаанд төсөвт ачааллыг үргэлжлүүлэн үзүүлэхээр байна.

1.27 Түүнчлэн концессын гэрээний эргэн төлөлтийн хуваариар санхүүжүүлэх дүн нь Монгол Улсын 2018-2020 оны төсвийн дунд хугацааны хөрөнгө оруулалтын зардлын тооцоололд тусгагдаагүй, ОУВС-тай тохирсон гэх Улсын төсвийн хөрөнгийн зардлын хязгаарт багтаагүй байна.

1.28 Концессын гэрээнд тусгасан эргэн төлөлтийн хуваарийн дүнгээс төсөвт дутуу тусгагдсан дүн 2017 болон 2018 оны нийлбэр дүнгээр 600.0 орчим тэрбум төгрөг байгаа нь 2018-2020 оны улсын төсөвт ихээхэн дарамт учруулах, мөн гэрээний нөхцөлийн дагуу концесс эзэмшигчид нэмэлт хүү, торгууль төлөх, эсхүл концессын гэрээний төлбөрийг төлөвлөгдөөгүй эх үүсвэрээс, нэмэлт хүүгийн зардал гаргаж санхүүжүүлэх эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

1.29 Иймд төсөв, санхүүгийн нөөц, боломжид нийцүүлэх замаар концессын төслийн зардал, ашгийн тооцоо, судалгаанд үндэслэн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 4. Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан гэрээний эргэн төлөлтийг улсын төсвийн хөрөнгийн зардалтай харьцуулсан судалгаа (тэрбум төгрөг, хувь)

ҮЗҮҮЛЭЛТ	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөлөл

		төсвийн тухай хуулиар	2018 он	2019 он	2020 он
Нэгдсэн төсвийн нийт зарлага		9,154.5	9,651.9	10,323.3	10,790.9
Нэгдсэн төсвийн нийт хөрөнгийн зардал		1,813.5	1,989.5	1,979.4	2,290.4
Нэгдсэн төсвийн нийт хөрөнгийн зардлын нийт зардалд эзлэх хувь		19.8	20.6	19.2	21.2
Төсвийн тухай хуулиар батлагдсан	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжих дүн	602.1	625.3		
	Концессын "барих-шилжүүлэх" төслийн эргэн төлөлтөд олгох санхүүжилтийн дүн	177.7	82.9		
Концессын гэрээний эргэн төлөлт, гэрээний дагуу		350.0	423.6	350.5	464.3
Эзлэх хувь	Нийт төсвийн зарлагад	3.8	4.4	3.4	4.3
	Нийт хөрөнгийн зарлагад	19.3	21.3	17.7	20.3
	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд	44.9	59.8		

Эх сурвалж: ҮАГ

1.30 Цаашид концессын “барих-шилжүүлэх” төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарийн дагуу санхүүжилтийн дүнг Монгол Улсын төсвийн хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төсвийн төсөөлөлд тусгах, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр гэрээг шинэчлэн байгуулах замаар төсвийг бодитой, үндэслэлтэй төлөвлөж байх шаардлагатай байна.

Концессын зүйлийн өртөг улсын төсвөөр баригдсан ижил хүчин чадалтай барилга, байгууламжийн төсөвт өртгөөс дунджаар 94.8 хувиар өндөр байна

1.31 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс санхүүжсэн, 2012-2017 онд барилга угсралтын ажил хийгдсэн ижил хүчин чадалтай барилгын дундаж өртгийг концессын төслийн өртөгтэй харьцуулж үзэхэд ойролцоогоор 42.7-121.5 хувиар өндөр байна.

Хүснэгт 5. Өртгийн харьцуулсан судалгаа (сая төгрөг)

Эх үүсвэр	Сургууль		Цэцэрлэг			1 км авто зам	1 метр гүүр
	960 суудал	640 суудал	150 ор	100 ор	75 ор		
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг*	5,422.0	4,065.6	1,342.2	760.6	1,061.6	636.8	14.5
Концессын зүйлийн гэрээний дүн	11,880.3	5,800.0	2,622.5	1,226.2	1,029.9	1,410.4	26.8
Зөрүү илүү (+), дутуу (-)	6,458.3	1,734.4	1,280.3	465.6	-31.7	773.6	12.3
Төсөвт өртгийн нэмэгдсэн хувь	119.1	42.7	95.4	61.2		121.5	84.8

*Эх сурвалж: ҮАГ. *Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэгжийн дундаж өртөг*

1.32 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн болон концессын зүйлийн гэрээгээр хэрэгжүүлсэн ижил төрлийн төсөл, арга хэмжээний үнийн дүн их хэмжээний зөрүүтэй байгаа нь концессын зүйлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын зээлийн хүү, концесс эзэмшигчийн менежментийн зардал болон даатгалын хураамж зэрэг өндөр дүнтэй зардал концессын зүйлийн гэрээний үнэд багтаж байгаатай холбоотой байна.

1.33 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга, байгууламжийн ашиглалтад орох хугацаа 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан арга хэмжээний хувьд дунджаар 5 жил байгаатай харьцуулахад концессын "барих-шилжүүлэх" төрлөөр баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгын ашиглалтад орох хугацаа харьцангуй бага буюу дунджаар 2 жил байна.

1.34 Гэрээ байгуулсан концессын зүйлийн хөрөнгө оруулалтын зардлын үндэслэл, тооцоолол бүрэн биш, хөрөнгө оруулалтын зардалд ямар зардлыг хүлээн зөвшөөрөх, тэдгээр зардлын зөвшөөрөгдөх зохистой хэмжээ, хязгаар хэд байх, хөрөнгө оруулалтын зардлыг концессын төрөл тус бүрд ялгавартай тооцох талаар аргачлалгүй байгаа учраас концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж буй 23 төсөлд хөрөнгө оруулалтын нэмэлт зардлын эзлэх хувь хэмжээ харилцан адилгүй тогтоогджээ. *(Дэлгэрэнгүйг хавсралт №2-т үзүүлэв.)*

Хүснэгт 6. Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын нэмэлт зардлын судалгаа

Гэрээний дагуу	Батлагдсан норм, стандартын дагуу
Зам, гүүр барих 8 ажилд хяналтын зөвлөх үйлчилгээний зардалд нийтдээ 34,365.5 сая төгрөгийг төсөвлөсөн нь гэрээний дүнгийн 5.0-5.3 хувийг эзэлж байна.	ЗТБХС-ын (хуучин нэрээр) 2012 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан "барилгын төсөв зохиох дүрэм"-д зааснаар "захиалагчийн албаны зардлыг барилга угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгээс 2%-аар тооцно, ... зөвлөх үйлчилгээ авсан тохиолдолд зөвлөх үйлчилгээний төслийн өртгийн 5%-аар тооцож, захиалагчийн албаны зардлыг давхардуулахгүйгээр олгоно.
Хүүхдийн цэцэрлэг барих 4, сургууль барих 1, спорт цогцолбор барих 1, авто зам барих 1, нийт 7 гэрээнд менежментийн зардалд нийтдээ 2,012.2 сая төгрөг, сургууль барих концессын 1 гэрээнд 348.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал тусгасан.	Ямар нэг батлагдсан стандарт, норматив хэмжээ байхгүй.
"Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн концессын 6 гэрээнд даатгалын зардалд нийтдээ 20,283.3 сая төгрөг тусгасан бол бусад гэрээнд даатгалын зардлыг огт тусгаагүй байна.	Концессын тухай хуулийн 26.5-д "*Концесс эзэмшигч нь концессын гэрээнд заасан тохиолдолд концессын зүйлийг гэнэтийн ослын даатгалд даатгуулах үүрэгтэй*", 30.1-д "Төрөөс дараах төрлийн санхүүгийн дэмжлэгийг концесс эзэмшигчид үзүүлж болно" гэсэн 30.1.4-д "*даатгалд хамруулах*" гэж заасан боловч гэрээгээр даатгалын зардал гэрээний үнийн дүнгийн 0.3-3.0 хувийг эзэлж, хэмжээ харилцан адилгүй байна.
"Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн концессын 20 төслийн хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн зардалд нийтдээ 211,575.5 сая төгрөг тусгасан бол бусад 3 гэрээнд зээлийн хүүгийн зардал огт тусгагдаагүй.	Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлд концессын төрлийг тодорхойлохдоо "*концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барих*" гэж заасан боловч сонгон шалгаруулалт явуулахдаа нийт хөрөнгө оруулалтад эзлэх өөрийн болон зээлийн хөрөнгийн харьцааг тооцох шалгуур үзүүлэлт тодорхойлогдоогүй, хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т уралдаант шалгаруулалтад оролцогчийг сонгон шалгаруулах эхний үзүүлэлт нь 13.3.1-д "*санхүүгийн чадавх*" гэж заасан ч зөвхөн оролцогч компанийн санхүүгийн чадавхад үнэлгээ хийдэг зэргээс шалтгаалан нийт хөрөнгө оруулалтад эзлэх зээлийн хэмжээ харилцан адилгүй, зээлийн хүү нийт гэрээт ажлын үнийн дүнгийн 6.7-37.4 хувийг эзэлж байна.

Эх сурвалж:ҮАГ

1.35 Энэ нь Концессын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан концесс олгох журамд төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад чиглэсэн шаардлага, зохицуулалт (худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа бага үнийн саналд илүү ач холбогдол өгөх, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөлтэй төсөл, арга хэмжээнд сонгон шалгаруулалт явуулдаг гэх мэт) тодорхой тусгагдаагүйтэй холбоотой байна.

1.36 Зээлийн хүү, менежментийн зардал, даатгалын хураамж зэрэг нэмэлт зардал нь ойролцоогоор гэрээний үнийн 19.6 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төслийн хувьд төсөвт нэмэлт ачаалал үүсгэх, бусад төрлөөр хэрэгжиж байгаа концессын төслүүдийн хувьд концесс эзэмшигчийн ашиглалтын өртгийг нэмэгдүүлэх, хугацааг уртасгах байдлаар тус тус нөлөөлж байна.

1.37 Ихэнх концесс эзэмшигч "*өөрийн боломжоор олсон*" хөрөнгийг хувь хүмүүс болон Банк бус санхүүгийн байгууллагаас өндөр хүүтэйгээр авсан зээлээр бүрдүүлж байгаа нь төсөл, арга хэмжээний өртөг нэмэгдэх шалтгаан болж байгаа тул концесс эзэмшигчийг шалгаруулахдаа санхүүгийн чадавхыг үндсэн шалгуур болгох, гаднаас татах хөрөнгө оруулалтын хэмжээ, хүүгийн төлбөр, өртөгт зохистой хэмжээг эзлэх хязгаарлалт тавьж байх шаардлагатай байна. Тухайлбал,

- *Нийслэлийн Баянгол дүүргийн 73 дугаар сургууль төслийн концесс эзэмшигч "Монкон констракшн" ХХК төслийн нийт хөрөнгө оруулалтын 69.7 хувийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлснээс Сингапур улсын "Foreland realty network Singapure" компаниар зуучлуулан жилийн 15.0 хувийн хүүтэйгээр Япон улсын харьяалал бүхий нийт 26 иргэнээс 3.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт авсан гэж тайлагнасан бөгөөд ингэснээр төслийн нийт өртөг 1.0 сая ам.доллараар нэмэгдсэн.*

- *Нийслэлийн Баянгол дүүргийн 38 дугаар сургууль төслийн концесс эзэмшигч "ӨВМТХ" ХХК нийт хөрөнгө оруулалтын 58.2 хувийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлснээс "Хаан кредит" ББСБ-аас 4.0 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 26.4 хувийн хүүтэй, Хаан банкнаас 1.5 тэрбум төгрөгийг жилийн 18 хувийн хүүтэй авч төслийн нийт өртөг 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.*
- *Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургууль барих төслийн концесс эзэмшигч "Цамхаг констракшн" ХХК төслийн нийт хөрөнгө оруулалтын харьцангуй бага хувь буюу 13.7 хувийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ч иргэдээс жилийн 24-36 хувийн хүүтэй зээл авч хүүгийн зардалд 461.3 сая төгрөг тус тус зарцуулсан зэргийг дурдаж болохоор байна.*

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА

Засгийн газар салбарын яамдаас санал болгоогүй төслүүдийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэснээс урьдчилсан судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээ жагсаалтад батлагджээ

2.1 Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор төрийн өмчийн концессын зүйлийн 125 төсөл, хөтөлбөрийг баталжээ.

2.2 Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор дээрх жагсаалтыг хүчингүй болгож, концессын зүйлийн 53 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 149 арга хэмжээ бүхий төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт (цаашид "жагсаалт" гэх)-ыг шинэчлэн батлахдаа 198 дугаар тогтоолд тусгагдсан 22 арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2.3 Дээрх жагсаалтад 2014-2017 оны хооронд Засгийн газрын нийт 29 удаагийн шийдвэрээр 115 арга хэмжээг нэмж, 22 арга хэмжээг хасаж, 115 арга хэмжээний төрөл, ажлын тоо хэмжээ, сонгон шалгаруулалт болон төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэлбэрт өөрчлөлт оруулжээ.

Хүснэгт 7. Төрийн өмчийн концессын зүйлийн төсөл, арга хэмжээний тооны өөрчлөлтийн судалгаа (тоо)

№	Салбарын ангилал	Концессын зүйлийн тоо (ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор)	Тогтоолд орсон өөрчлөлтүүд								Нийт		
			2014		2015		2016		2017				
			Нэмэгдсэн	Хасагдсан	Нэмэгдсэн	Хасагдсан	Нэмэгдсэн	Хасагдсан	Нэмэгдсэн	Хасагдсан	Нэмэгдсэн	Хасагдсан	Концессын зүйлийн тоо (2017/12/31 байдлаар)
1	Дэд бүтэц, барилга байгууламж	**9**	1		23		3			1	**27**	**1**	**35**
2	Авто зам	**31**			6	8	6	2	4		**16**	**10**	**37**
3	Хоолойн тээвэр	**2**				2						**2**	
4	Нисэх буудал	**2**					2				**2**		**4**
5	Эрчим хүч	**13**			8	2	1	2			**9**	**4**	**18**
6	Байгаль орчин	**4**			1	1	1				**2**	**1**	**5**
7	Боловсрол	**84**			2		43				**45**		**129**
8	Эрүүл мэнд	**1**	3		3						**6**		**7**
9	Соёл, амралт	**3**	2			4	1				**3**	**4**	**2**
10	Төмөр зам		1				1				**2**		**2**
11	Мэдээлэл, харилцаа холбоо				1		2				**3**		**3**
	Бүгд	**149**	**7**		**44**	**17**	**60**	**4**	**4**	**1**	**115**	**22**	**242**

Эх сурвалж: ҮАГ

2.4 Концессын зүйлийн жагсаалтад салбар хариуцсан яамдаас санал болгоогүй төслүүдийг баталсан нь Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4[16] дэх заалтыг зөрчиж, зардал ашгийн тооцоо боловсруулаагүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, ач холбогдлоор нь эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээ цөөнгүй багтсан байна. Тухайлбал,

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол:

- *Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам төсөл,*
- *Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл,*
- *"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт,*
- *Багануурын цахилгаан станц төсөл,*
- *Чандганы цахилгаан станц барих төслийг эрчим хүчний хэрэглээтэй уялдуулан жагсаалтаас хасуулах саналыг салбар яамнаас 2015 онд ЭЗХЯ-нд, 2016 онд ҮХГ-т өгсөн боловч хасагдаагүй,*

Засгийн газрын 2015 оны 306 дугаар тогтоол:

- *Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төсөл,*

[16] 9.4."Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ"

Засгийн газрын 2016 оны 73, 74, 226, 263, 273, 307 дугаар тогтоол:

- *УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоолд боловсролын салбарт концессын гэрээгээр хэрэгжүүлэх 25 төслийн нэр, байршлыг батлан, барилгыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Загийн газарт үүрэг болгожээ. Дээрх тогтоолоор "нэг маягийн зураг төслөөр 2016 онд концессоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-д боловсролын салбарын 25 төслийг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр баталсан хэдий ч ҮХГ-аас 35 төслийг концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг хүргүүлж Засгийн газрын 2016 оны 73, 74 дүгээр тогтоолоор батлуулсан байна,*
- *Шаамар-Цагааннуур-Түшиг 135 км хатуу хучилттай авто замын ажлыг "Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл" болгон өөрчлөхдөө салбарын яамнаас санал аваагүй,*
- *Нисэхийн арын товчооноос шинэ авто худалдааны цогцолбор хүртэлх авто зам дагуу Туул гол дээр 310.2 у/м гүүр, Морингийн даваанд гэр хорооллоос Авто худалдааны цогцолбор хүртэлх 3.6 км авто зам барих төсөл,*
- *Нарантуул олон улсын худалдааны төвийн гүүрэн гарц барих төсөл,*
- *АСЕМ-ын чуулга уулзалт зохион байгуулагдахтай холбогдуулан "Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.1 км сайжруулсан шороон зам, 0.3 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 авто машины зогсоол барих төсөл",*
- *Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Согоогийн голын 27 уртааш метр төмөр бетон гүүр барих төсөл,*
- *Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвийг улсын чанартай авто замтай холбох 7 км хатуу хучилттай авто зам төсөл,*

Засгийн газрын 2017 оны 26 дугаар тогтоол:

- *Дорноговь аймгийн Сайншанд сум болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам зэрэг арга хэмжээнүүд байна.*

Концессын зүйлийг хэрэгжүүлэх хугацаа, стратегийг тодорхой болгож, жагсаалтыг шинэчлэн батлах шаардлагатай байна

2.5 Концессын зүйлийн жагсаалтад батлагдсан гэрээ байгуулагдаагүй 184 арга хэмжээ байгаагаас 106 арга хэмжээ буюу 57.6 хувь нь Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор жагсаалтад тусгагдсанаас хойш 5 жил өнгөрсөн байна.

Дүрслэл 2. Концессын зүйлийн батлагдсан болон гэрээ байгуулсан төслийн тоо



2.6 Жагсаалтыг батлахдаа концессын зүйлүүдийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгаагүйгээс өнөөдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй байгаа 184 арга хэмжээг цаашид концессоор хэрэгжүүлэх шаардлагыг эргэн авч үзэх нь зүйтэй.

2.7 Жагсаалтыг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулаагүйгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээ жагсаалтад тусгагдсантай давхцаж байна. Тухайлбал,

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол:

- *Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр (улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа)*

Засгийн газрын 2014 оны 313 дугаар тогтоол:

- *Сувилгаа, асаргаа, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний төв байгуулах төсөл (Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан);*
- *Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулах (Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймагт хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулахаар батлагдсан),*

Засгийн газрын 2015 оны 306, 333 дугаар тогтоол:

- *Улаанбаатар-Мандалговь 330 кВ-ын ЦДАШ, 2 ширхэг 220 кВ-ын дэд станц барих төсөл (БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр ЭХЯ 2017оноос хэрэгжүүлж эхэлсэн);*
- *Замын-Үүд чөлөөт бүсийн 2-р ээлжийн дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуургын ажил болон Замын-Үүд чөлөөт бүсийн 2-р ээлжийн авто зам, гэрэлтүүлэг, холбооны байгууламжийн ажлууд (БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр БХБЯ 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн)*

2.8 Иймд ТХХТ-ийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

Концесс эзэмшигчийг сонгох аргыг тодорхойлох, шалгаруулалт явуулахдаа холбогдох хууль, журмыг зөрчсөн байна

2.9 Засгийн газраас концессын зүйлийн жагсаалтыг батлахдаа концессын нийт 242 арга хэмжээний 51.2 хувь буюу 124 арга хэмжээнд концесс эзэмшигчтэй шууд гэрээ байгуулах, 48.3 хувь буюу 117 арга хэмжээнд уралдаант шалгаруулалтын аргаар гэрээ байгуулахаар холбогдох тогтоолд заасан нь Концессын тухай хуулийн 11.1[17]-д заасныг зөрчиж, өрсөлдөөнийг хязгаарласан байна.

Дүрслэл 3. Концесс эзэмшигчийг сонгох хэлбэр, салбарын ангиллаар



2.10 Засгийн газраас Концессын тухай хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүсээгүй байхад "шууд гэрээ байгуулах"-аар баталснаас нийт гэрээ байгуулсан концессын 57 зүйлийн 42.1 хувь буюу 24 арга хэмжээний концесс эзэмшигчийг шууд аргаар сонгосон байна. Үүнд:

- *Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих 1,762.0 сая төгрөгийн гэрээг "Наранбулаг Хан" ХХК-тай;*
- *Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам барих 26,640.0 сая төгрөгийн гэрээг "Пик девелопмент" ХХК-тай;,*
- *Сэлэнгэ аймгийн Мандал сумын дулааны төв шугам, дулааны дэд станц, бохирын шугам барих 18,619.5 сая төгрөгийн гэрээг "Бумбод" ХХК-тай,*
- *Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэлх 110 кВт-ын ЦДАШ, өргөтгөл, дэд станц барих 112.6 сая ам.долларын гэрээг "Кью Эс Си" ХХК-тай;*
- *Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих 95,272.2 сая төгрөгийн гэрээг "Кью Эс Си" ХХК-тай;*
- *Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах 11,346.9 сая төгрөгийн гэрээг "Ай Эй И" ХХК-тай;*
- *Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох 400.0 сая төгрөгийн гэрээг "Маргад Монгол" ХХК-тай;*
- *Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) хүртэлх 33.4 км 1520 мм царигтай*

[17] Энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд концессыг төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт /цаашид "уралдаант шалгаруулалт" гэх/ -ын аргаар олгоно.

төмөр зам, ачиж буулгах терминалын хамт барих 106.9 сая ам.долларын гэрээг "Кью Эс Си" ХХК-тай;

- *Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажлын 98.3 сая ам.долларын гэрээг "Чайна гэжуба групп" компанитай;*
- *Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл/ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын 32.2 сая ам.долларын гэрээ "Монголын алт"(МАК) ХХК-тай;*
- *Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр зам барих ажлын 1,300.0 сая ам.долларын гэрээг "Нортерн Рэйлвэйс" ХХК-тай;*
- *"Туул-Сонгино" усны нөөцийн цогцолбор барих ажлын 350.0 сая ам.долларын гэрээг "Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц" ХХК-тай;*
- *"Тэлмэний дулааны цахилгаан станц"барих ажлын 183.4 сая ам.долларын гэрээг "Шинэ Азиа Групп" ХХК-тай;*
- *Увс аймгийн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам барих ажлын 119.8 сая ам.долларын гэрээг "Баруун Монгол Энержи" ХХК-тай;*
- *Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагаа, хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөл, техник технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмрийн хүдэр боловсруулж, төмөрлөгийн цогцолбор байгуулж эцсийн бүтээгдэхүүн гаргах гэрээг "Кью Эс Си" ХХК-тай;*
- *Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл/ Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын барилга барих 55.0 сая ам.долларын гэрээг "Нэйшнл Трэйдинг энд Транспорт Групп" ХХК-тай;*
- *Хүний хөгжлийн төв цогцолбор байгуулах гэрээг "Жам Зам Инвестмент" ХХК-тай;*
- *Монгол угсаатны үндэсний музейн цогцолбор байгуулах 125.0 сая ам.долларын гэрээг "Секрет Монголс" ХХК-тай;*
- *Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулах төсөлд 2015 онд "Рич Голден Буллс Эдүкэшн" ХХК-тай;*
- *Сургуулийн барилга барих 16,598.5 сая төгрөгийн 4 гэрээг "Ганьт", "Монкон констракшн", "Цамхаг констракшн", "ӨВМТХ" ХХК-иудтай тус тус байгуулахдаа гүйцэтгэгчийг шууд сонгожээ.*

2.11 Нийт гэрээ байгуулсан 57 концессын зүйлээс үлдэх 57.9 хувь буюу 33 арга хэмжээний концесс эзэмшигчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулахад 13 арга хэмжээний хувьд амжилттай болсон бол 20 арга хэмжээний хувьд амжилтгүй болж, шууд гэрээ байгуулах аргыг сонгожээ.

2.12 Концессын тухай хуулийн 13.10 дахь "ажлын хэсгийг ... томилон ажиллуулж болно" гэсэн заалт нь тодорхой бус байгаагаас, жишээ нь Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замын төсөлд ХОГ (хуучин нэрээр) нь уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулаагүй, оролцогчийн саналыг тус газрын КТХХТ-ийн хэлтсийн зөвхөн нэг мэргэжилтэн үнэлж, дүгнэлт гаргасан байна.

2.13 Мөн концесс олгох уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичигт оролцогчийн санхүүгийн саналд "төслийн зардлын задаргаа", "санхүүжилтийн төлөвлөгөө", "санхүүгийн загвар" зэргийг тусгахаар заасан хэдий ч концессын төслүүдэд уг жишиг баримт бичгийн дагуу боловсруулсан санал ирээгүй, энэ талаар зохих шийдлийг гарган ажиллаагүй байна.

2.14 Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор баталсан "*Концесс олгох уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам*"-ын уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан ч гишүүд мэдүүлгийг бүрэн гаргаагүй байна. Тухайлбал,

- *Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн ажлын хэсгийн 7 гишүүн*[18],
- *Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц барих ажлын хэсгийн 6 гишүүн*[19],
- *Багануурын цахилгаан станц барих төслийн ажлын хэсгийн 7 гишүүн*[20],

[18] ҮХГ-ын КТХХТ-ийн ажлын албаны дарга О.Мөнхтөр, гишүүд ҮХГ-ын КТХХТ-ийн албаны ахлах мэргэжилтэн Г.Содбаяр, мэргэжилтэн М.Мандах, Н.Баярчимэг, ЭХЯ-ны ХОҮХ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Сугар, Бодлого,төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Ш.Ганзориг, Сангийн яамны ТХОГ-ын мэргэжилтэн Б.Ганзориг

[19] ҮХГ-ын КТХХТ-ийн ажлын албаны дарга О.Мөнхтөр, гишүүд ҮХГ-ын КТХХТ-ийн албаны ахлах мэргэжилтэн Г.Содбаяр, мэргэжилтэн Н.Баярчимэг, ЭХЯ-ны БТГ-ын мэргэжилтэн И.Лувсанцэрэн, Сангийн яамны ТХОГ-ын мэргэжилтэн Б.Ганзориг

[20] П.Товуудорж, Л.Мөнхцог, Вандандорж, Д.Тулга, М.Мөнхтулга, Д.Цэвэлмаа, С.Оюундэлгэр

- *Дундговь аймгийн Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэгийн барилга барих төслийн ажлын хэсгийн 4 гишүүн*[21],
- *Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн сайжруулах төслийн ХОГ-ын даргын 2015 оны 1/141, 2015 оны А/164 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 11 гишүүн*[22],
- *Дорноговь аймгийн Сайншанд сум болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам барих төслийн ҮХГ-ын даргын А/46 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 5 гишүүн*[23] *мэдүүлэг гаргаагүй байна.*

2.15 Холбогдох үндэслэл хангалттай бүрдээгүй байхад дараах тохиолдлуудад уралдаант шалгаруулалтыг хүчингүй болгосон, журамд заагаагүй нөхцөлөөр уралдаант шалгаруулалтыг явуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

Хэлэлцээ хийсэн боловч урилга хүргүүлэх байгууллагыг хэрхэн сонгосон, хэлэлцээрт ямар асуудлуудыг тусгасан талаар баримт материал байхгүй:

- *Авто замын төслүүдийн хувьд: Ажлын хэсгийн 2014.07.01-ний өдрийн хуралдаанаар "Нью саймин ресорсос", "Лун Зянь Роуд энд Бридж" компаниудын ирүүлсэн төслийн саналыг хянаж үзэхэд эдгээр оролцогчид концесс олгох уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журмын 5.15.1-д заасан ерөнхий шаардлагыг хангаагүй тул уралдаант шалгаруулалт хүчингүй болсон,*
- *Баянхонгор аймгийн 6 цэцэрлэг: Концессын зүйлийн жагсаалтад нэмэх тухай Засгийн газрын тогтоолд Баянхонгор аймагт хэрэгжих 6 цэцэрлэг нь 1 төсөл болж батлагдсан тул 6 цэцэрлэгийн төсөлд зэрэг оролцох гүйцэтгэгч ирээгүй нь уралдаант шалгаруулалт амжилтгүй болоход хүргэсэн байна.*

Журамд зөвшөөрөгдөөгүй аргаар сонгон шалгаруулалтыг явуулсан:

- *Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн авто зам барих төслийн уралдаант шалгаруулалтыг 2 удаа явуулсан бөгөөд хоёрдугаар шатны уралдаант шалгаруулалтыг "хязгаарлагдмал уралдаант шалгаруулалт" гэсэн хууль, журамд тусгагдаагүй нөхцөлөөр зохион байгуулжээ.*

2.16 Сонгон шалгаруулалт явуулахдаа бага үнийг сонгох, арвилан хэмнэлттэй байх зарчмыг алдагдуулж, сонгон шалгаруулалтад оролцогчийн ирүүлсэн саналаас өндөр үнээр гэрээ байгуулсан байх тул холбогдох асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулах нь зүйтэй байна. Тухайлбал,

- *Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж буй 300 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусгах, дэд бүтэц барих концессын гэрээг хэрэгжүүлэхээр 4 компаниас харгалзан 24,150.0 сая төгрөг, 22,555.0 сая төгрөг, 27,087.4 сая төгрөг, 26,618.2 сая төгрөгийн тус бүр үнийн дүнтэй санал ирүүлэхэд, 22,555.0 сая төгрөгийн санал ирүүлсэн Томо бюлдинг ХХК-ийг шалгаруулж, 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр гэрээг 25.7 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй байгуулжээ.*
- *Шууд гэрээ байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар үндсэн шалгуур үзүүлэлтэд шаардагдах материалыг дутуу ирүүлсэн Фарго индастри ХХК, Эн Эйч и Энд Си ХХК-уудыг хасаж, Хар чонот ХХК (зээлийн хүүгийн зардал ороод 24,150.0 сая төгрөгийн санал ирүүлсэн), Томо бюлдинг ХХК тус бүртэй уулзаж, нэмэлт хэд хэдэн тодруулга авахаар шийдвэрлэж, 2017 оны 4 дүгээр сарын 11-нд уулзалт зохион байгуулсан байна. Тухайн өдрийн эхний уулзалтаар Томо бюлдинг ХХК нь саналд тусгасан үнээр буюу 20.9 тэрбум төгрөгөөр төслийг гүйцэтгэх боломжтой гэж байсан боловч үдээс хойших уулзалтаар гадаадын хөрөнгө оруулалт бүтэхгүй болсон тул үнийн саналаа 14.05 хувиар буюу 3,169.6 сая төгрөгөөр өсгөж 25.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгэх болсон тухай мэдэгдсэн байхад тус компанийг сонгон шалгаруулсан нь Концессын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4*[24] *дэх заалтыг зөрчсөн байна.*
- *Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолд санал авах тухай 01/63 тоот албан бичгийг ҮХГ-аас 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Сангийн яаманд хүргүүлж, Сангийн сайд тухайн өдөртөө багтаан 9/2080 тоот албан бичгээр дэмжих боломжгүй гэсэн хариу хүргүүлсэн боловч Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 13-ны "Концессын гэрээ байгуулах эрх олгох" тухай 120 дугаар тогтоол гарч, тухайн өдөр Үндэсний хөгжлийн газар, Томо бюлдинг ХХК-тай концессын гэрээ байгуулсан нь Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолын 1*[25] *дүгээр заалтыг зөрчсөн байна.*

[21] ХОГ-ын КТХХТ-ийн хэлтсийн дарга Ц.Батбаяр, гишүүд мэргэжилтэн Э.Ган-Эрдэнэ, Д.Мөнхтэгш, БСШУСЯ-ны СЭЗГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ганбаатар, Э.Ган-Эрдэнэ

[22] Ажлын хэсгийн ахлагч, ҮХГ-ын КТХХТ-ийн хэлтсийн дарга Ц.Батбаяр, гишүүд ҮХГ-ын КТХХТ-ийн мэргэжилтэн З.Мэргэн, Д.Алтанбилэг, ЗТЯ-ны АТБХЗГ-ын АТХ-ийн мэргэжилтэн Ш.Хавидолда

[23] ҮХГ-ын КТХХТ-ийн албаны дарга, ажлын хэсгийн ахлагч О.Мөнхтөр, гишүүд ҮХГ-ын КТХХТ-ийн албаны ахлах мэргэжилтэн Г.Содбаяр, мэргэжилтэн Н.Баярчимэг, М.Мандах, ЗТЯ-ны АТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа

[24] Эрх бүхий этгээд төслийн саналыг энэ хуулийн 14.3-т заасны дагуу харьцуулан үнэлж хамгийн сайн нөхцөл санал болгосноос нь эхлэн дараалуулсан жагсаалт гаргана.

[25] Концессын зүйлийн жагсаалтад "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр тусгасан улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээг 2018 оны төсвийн жил хүртэл аливаа этгээдтэй байгуулахгүй байх.

- *Концессын гэрээний 2 дугаар зүйлийн 2.16-д[26] заасны дагуу ҮХГ-ын 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 01/681 тоот албан бичгээр гэрээ хүчин төгөлдөр болсон тухай мэдэгдлийг концесс эзэмшигчид хүргүүлсэн боловч, "Концесс эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөлийг хянасан дүгнэлт"-ийн 2 дугаарт "Зохиогчийн хяналт тавих этгээдүүдтэй байгуулсан гэрээг эрх бүхий этгээдэд ирүүлэх" гэсэн нөхцөл биелэгдээгүй байхад дээрх мэдэгдэл хүргүүлсэн нь гэрээний 2 дугаар зүйлийн 2.17.2 дахь заалтыг зөрчсөн байна.*

Концессын зарим төсөл эдийн засгийн хувьд үр ашигтай байх боловч төрийн дэмжлэг, зохицуулалт дутагдалтай байгаагаас хэрэгжилт хангалтгүй байна

2.17 Концессын төслүүд хугацаандаа хэрэгжих нэг нөхцөл болсон газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүдийг захиалагч байгууллага хугацаанд гаргаж өгөөгүй, шийдвэр гаргалт удаашралтай байгаагаас концессын зүйл хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

- *Дулааны 5 дугаар цахилгаан станц барих төслийн концессын гэрээ байгуулах эрхийг Засгийн газрын 2014 оны 187 дугаар, Засгийн газрын 2012 оны 191 дүгээр тогтоолоор төслийг нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Хөлийн хөндийн 43.0 га газарт хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ч уг газрын өмнөх эзэмшигчийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй. Ус ашиглах гэрээг өнөөг хүртэл байгуулж чадаагүйгээс төслийн усан хангамжийн асуудал шийдэгдээгүй хэвээр байна.*
- *Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг 2015 онд "Рич голден буллс эдүкэшн" ХХК-тай байгуулсан гэрээт ажлын хүрээнд 30 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барих газрыг концесс эзэмшигчид хугацаанд гаргаж өгөөгүйгээс гэрээний үүргийн хэрэгжилт удааширч улмаар ХОГ (хуучин нэрээр) гэрээ цуцлах шийдвэр гаргасан.*

2.18 Концессын дараах төслүүд төсөвт ачаалал үүсгэхгүй, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай байх боловч тодорхой зохицуулалт, дэмжлэг дутагдалтай байгаагаас концесс эзэмшигчид эрсдэлд орж болзошгүй байна. Тухайлбал,

- *"Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор" концессын төслийг Морьт-импекс ХХК санаачилж, Засгийн газрын тогтоолоор шууд гэрээ байгуулах эрх олгосон. Төслийг хэрэгжүүлснээр хоногт 200000м3 бохир усыг цэвэрлэж дахин ашиглах хүчин чадалтай үйлдвэр байгуулах, 110 МВт хүчин чадалтай ОХУ-ын импортын цахилгааныг хаах хэмжээний цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх тооцоолол хийсэн байна. Төслийн ТЭЗҮ боловсруулагдаж, барилгын ажлын "Түлхүүр гардуулах нөхцөлтөй ФИДИК-ийн EPC гэрээ"-г 2014.11.18-ны өдөр Шанхай хотод байгуулсан, Хонг Конгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй АНУ-ын "Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын сан" ХК-тай 2015 оны 7 дугаар сард, АНУ-ын Вашингтон хотод бүртгэлтэй тусгай зориулалтын "Монголын хөрөнгө оруулалтын групп" ХК-тай 2016 оны 8 дугаар сард тус бүр 260.0 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан. Энэхүү концессын төсөлд Засгийн газар ямар нэг барьцаа баталгаа гаргаагүй, хөрөнгө оруулалтын зээлийг эргүүлэн төлөх баталгаа болсон "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ" (PPA) болон "Хотын бохир усыг цэвэрлэж дахин ашиглах тухай хамтын ажиллагааны гэрээ" (WPA) хэлцэл хийгдсэн, ашиглалтын хугацаанд улсын төсөвт ямар нэг дарамт үүсгэхгүйгээр зохион байгуулагдсан байна. Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа 2015 оны 2 дугаар сард дуусан боловч сунгагдаагүй байна. Концесс эзэмшигч гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах нөхцөл, шаардлагыг биелүүлсэн боловч өнөөдрийг хүртэл гэрээг хүчин төгөлдөр болгоогүйгээс концесс эзэмшигчийн үйл ажиллагаа доголдох, концессын зүйл цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.*

Концессын гэрээгээр бодлогын зорилттой нийцэхгүй, хууль зөрчсөн, үр ашиггүй хөрөнгө оруулалт хийж байна

2.19 ҮХГ-аас концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар барих-шилжүүлэх төрлийн гэрээний эргэн төлөлтийг хойшлуулах, ажлын тоо хэмжээг бууруулж төсөвт ирэх ачааллыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр нийт 5 гэрээнд нэмэлт, өөрчлөлтөөр 3 төслийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулж, 3 гэрээний үнийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкнаас зарласан ханшаар тооцоход 57.2 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Үүнд:

Эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, төсөвт өртгийг бууруулсан:

- *Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км хатуу хучилттай авто замын ажлын эргэн төлөлтийг 2017-2019 онд хийхээр өөрчилж, гэрээний үнийг 49.0 тэрбум төгрөгөөр,*

[26] Гэрээнд талууд гарын үсэг зурснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 3 сарын дотор концесс эзэмшигч нь дор дурдсан урьдчилсан нөхцөлийг бүрэн хангасан нь энэхүү гэрээ хэрэгжих үндэслэл болно.

- *Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төслийн эргэн төлөлтийг 2020-2022 он болгон хойшлуулж, төсөвт өртгийг 3.1 сая ам.долларааp,*
- *Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төслийн эргэн төлөлтийг 2020-2021 он болгон хойшлуулж, гэрээний үнийг 2.0 сая юаниар тус тус бууруулсан,*

2.20 Гэвч концессын барих-шилжүүлэх төрлөөр ТХХТТ төрөөс баримтлах бодлогын 1.3.2-т заасан "... *нэгдсэн төсвийн үр ашгийг дээшлүүлэх ...*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т заасан *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 6.4.2-т заасан "*төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх*" гэсэн зарчмуудтай нийцээгүй төрийн чиг үүрэгт хамааралгүй дараах төслийг хэрэгжүүлж, санхүүжүүлсэн байна. Үүнд:

- *Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 1.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төслийн хүрээнд төрийн өмчийн оролцоогүй хувийн аж ахуйн нэгжийн эзэмшил газарт 400 автомашины зогсоолыг нэг удаагийн арга хэмжээ (ACEM)-ний хүрээнд барьж, төсвөөс санхүүжүүлсэн.*
- *Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах 30 жилийн хугацаанд хэрэгжих, нийт зургаан хэсэг буюу "шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлийн 5, "барих-шилжүүлэх" төрлийн 1 хэсгээс бүрдсэн, 2014 оны 4 дүгээр сарын 04-нд байгуулсан концессын гэрээнд 2015 оны 10 дугаар сарын 2-ны өдөр "Нэмэлт гэрээ"-ээр өөрчлөлт оруулж, "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Хандгай өртөө чиглэлийн 33,4 км 1540 мм-ийн царигтай төмөр зам, ачиж буулгах терминал", "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын автозамын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хүнд даацын хатуу хучилттай автозам"-ыг "барих-шилжүүлэх" болгон өөрчилж, тус концессын гэрээний "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжих хэсгийг 3 болгожээ.*

  Тус 2 арга хэмжээнд бүгд 372.0 тэрбум төгрөг олгохоос зураг төсөл нь магадлалаар баталгаажаагүй, ажлын гүйцэтгэл хянагдаж, баталгаажаагүй байхад 2016 онд 240,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2[27] дахь заалтыг, мөн Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3[28], 3.5[29], 3.5.3[30], 3.5.6[31] дахь заалтуудыг зөрчсөн байна. Түүнчлэн Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2015 оны 02/18/15 тоот комиссын актаар Төмөртэйн уурхай чиглэлийн 22.9 км төмөр замыг, өртөөний хамт хүлээн авч, ЗГ-ын 2016 оны "Концессын зүйлийг төрийн өмчид шилжүүлэх авах тухай" тогтоолын дагуу "Монголын төмөр зам" ХХК өөрийн тайлан балансад бүртгэхээр шийдвэрлэсэн зэргээс харахад гэрээнд зааснаас 10.5 км төмөр зам дутуу байгаа талаарх тайлбарыг Сангийн яам, ҮХГ-ын холбогдох албан тушаалтнууд гаргаж өгөөгүй болно.

  Түүнчлэн Засгийн газрын 2015 оны 364 дүгээр тогтоолыг үндэслэн Хөрөнгө оруулалтын газар "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд төмөр ерөө гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж, буулгах терминалын хамт барих" ажлын гэрээний дагуу 2016 онд төлөх бодит хөрөнгө оруулалтын 80 хувь буюу 183.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохдоо УИХ-ын холбогдох шийдвэргүйгээр, Засгийн газрын 2016 оны 77 дугаар тогтоолоор векселиэр олгохоор шийдвэрлэсэн. Үүний дагуу 2016.02.26-нд Хөгжлийн банкаар дамжуулан Төрийн банканд 183.6 тэрбум төгрөгийн вексель бичигдэж, санхүүжилт олгосон бөгөөд 2017.02.24-ний өдөр үндсэн төлбөрт 183.6 тэрбум, хүүгийн төлбөрт 27.3 тэрбум төгрөгийг арилжааны банканд төлсөн байна.

  ҮХГ-ын 2016 оны 01/174 тоот албан бичгээр Сангийн яаманд дээрх арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж өгөх хүсэлтийг хүргүүлж, Сангийн сайдын 2016 оны 8/6758 тоот албан бичгээр тус төсөл, арга хэмжээний талаар холбогдох баримт материал ирүүлээгүй тул санхүүжилтийн эрхийг нээх боломжгүй гэсэн хариу өгсөн боловч Сангийн яамны ТНбД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч,

[27] Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

[28] Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.

[29] СЯ-ны Төсвийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн нь энэхүү журмын 1 болон 2-р хавсралтаар батлагдсан Хяналтын хүснэгтэд тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг хянаж, санхүүжүүлнэ

[30] Тендерт шалгарч гэрээ байгуулсан этгээдийн барилга угсралт, их засварын ажлын төлөвлөгөө, түүнийг төсөвт өртөгт эзлэх дүнгээр тодорхойлсон барилгын санхүүжилтийн хуваарь /энэ журмын 4-р хавсралтаар батлагдсан маягтын дагуу/ гаргана.

[31] Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл /энэ журмын 3,4-р хавсралтаар батлагдсан маягтын дагуу/ гаргана.

ТСГ-ын дарга нар эрх нээж, 2016.12.27-нд 57.2 тэрбум төгрөгийг концесс эзэмшигчид шилжүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) хүртэлх 33.4 км 1520 мм царигтай төмөр зам нь Сэлэнгэ аймгийн Ерөө суманд орших Баянголын орд хүртэл тавигдсан бөгөөд одоогийн байдлаар тус ордыг БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай "Болд төмөр ерөө гол" ХХК эзэмшдэг.

2.21 Иймд өртөг өндөртэй "Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км 1520 мм царигтай төмөр зам" төслүүдийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг холбогдох хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй байна.

Нийт концессын 74.6 хувийг "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байгаа нь олон улсын нийтлэг хандлагаас зөрүүтэй байна

2.22 ТХХТ-ийг ашигладаг орнуудаас БНСУ, БНТУ, ОХУ, ХБНГУ зэрэг улсуудад ТХХТ-ийг хэрэгжүүлж байгаа байдал, концессын зүйлийн нийтлэг төрлүүдийг судалж үзэхэд ТХХТ-ийг хэрэгжүүлж байгаа тогтолцоо харилцан адилгүй боловч түншлэлийг ихэвчлэн концессын "барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байна. (*Судалгааны дүнг хавсралт №4-өөс харна уу*)

2.23 Олон улсын туршлагаас харахад тухайн төслийн цар хүрээ бага, төслийг хэрэгжүүлэгч нь мэдлэг, туршлага дутмаг, төсөл хэрэгжих хугацаа хэт богино байх тохиолдолд концессыг хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үздэг бол Монгол улсад хэрэгжиж байгаа барих-шилжүүлэх төрлийн төслүүд нь зардал, ашгийн тооцоолол хийгдээгүй, дийлэнх нь 1-2 жилийн хугацаанд дуусгавар болохоор байгаа нь ТХХТ-ээр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бага, төсвийн шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслөөс цаг хугацаа, төсөвт учруулах нөлөөллийн хувьд ялгагдахааргүй байна.

2.24 Дээрх улсад ТХХТ-ийг хэрэгжүүлэх төрөл, зүйлийг сонгох, төслийг судлах, эхлүүлэхэд ул суурьтай хандаж, төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдэхдээ тоо, чанарын тооцоо, судалгаа, үр ашигт үндэслэдэг нь төсөл амжилттай хэрэгжих нөхцөл болдог байна.

2.25 Иймд цаашид ТХХТ-ийг хөгжүүлэхдээ "барих-ашиглах-шилжүүлэх" төрлийн концессыг түлхүү хэрэгжүүлэх шаардлагыг авч үзэх нь зүйтэй байна.

Хүснэгт 8. Концессын гэрээний хэрэгжих хугацаа (жил, тоо)

Концессын төрөл	Төсөл хэрэгжих хугацаа	ТАХ-ний тоо
Барих-ашиглах-шилжүүлэх	17 жил	1
	20-25 жил	4
	30 жил	4
Барих-шилжүүлэх	1 жил хүртэл	18
	1-2 жил	17
	2-3 жил	5
	4 жил	1
	30 жил	2
Барих-өмчлөх-ашиглах	20-25 жил	3
	30 жил	1
Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх	30 жил	1
НИЙТ		57

Хяналтын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль зөрчсөн байна

2.26 ҮХГ нь ТБОНӨХБАҮХҮТХ-ийн нэгдүгээр бүлгийн 8 дугаар зүйлийн 8.1.3[32]-т заасны дагуу Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "*зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаар*"-аас давсан концессын төслүүдийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер зарлаж, сонгон шалгаруулалт явуулалгүйгээр Аж үйлдвэрийн сайдын /*хуучин нэрээр*/ 2015 оны 73 дугаар тушаалаар "*концессын барих-шилжүүлэх төрлөөр гэрээ байгуулсан автозамын төслүүдэд хяналт тавих зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох*" ажлын хэсэгт зориулан нэг удаагийн үйлчлэлтэй баталсан удирдамжийг үндэслэн ХОГ (хуучин нэрээр)-аас 9 автозамын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг хууль зөрчин сонгосон байна.

[32] Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

2.27 ХОГ (хуучин нэрээр)-аас 8 аж ахуйн нэгжид гэрээ байгуулах эрх олгосноос 2015 онд 4 аж ахуйн нэгжтэй 10,044.2 сая төгрөгийн гэрээ байгуулснаас 3 төслийн хэрэгжилт дуусч, 6,763.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон, харин 1 төсөл шүүхийн маргааны улмаас зогсонги байдалд орсон байна.

2.28 Тухайн үед хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулагдаагүй, ажил эхлээгүй байсан 2 төсөлд ҮХГ-аас 10,468.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжүүлэхээр тохиролцсон байна. Үүнд:

- *Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замын төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг 2016 онд "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай байгуулсан бөгөөд замын ажилд хяналт хийх зөвлөх үйлчилгээний 5,413.4 сая төгрөгийн гэрээг 2017 оны 12 дугаар сард буюу 1.5 жилийн дараа "Эм си пи си жи ар" ХХК-тай байгуулахдаа гэрээний тусгай нөхцөлийн 6.4-т "гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс ажлын 10 хоногт гэрээний үнийн дүнгийн 30 хувийг, автозамын ажлын явц 50 хувьтай болсныг тайлангаар баталгаажуулснаас хойш 30 хувийг олгохоор буюу автозамын ажилд хяналт хийж эхлээгүй байхад 30 хувь, автозамын ажил 50 хувьтай байхад, хяналтын зөвлөх үйлчилгээний хөлсний 60 хувийг гүйцэтгэгчид олгохоор заасан байна.*
- *Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай автозамын барилга барих төслийн "барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээг "Хос мөнгөн зам" ХХК-тай 2017 оны 2 дугаар сарын 3-нд байгуулсан бөгөөд замын ажлын гүйцэтгэлд хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх 5,055.2 сая төгрөгийн гэрээг "Ар Си Эс Си" ХХК-тай 2017 оны 11 дүгээр сарын 29-нд байгуулж, гэрээний тусгай нөхцөлийн 6.4-т "гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс ажлын 10 хоногт гэрээний үнийн дүнгийн 30 хувийг, автозамын ажлын явц 50 хувьтай болсныг тайлангаар баталгаажуулснаас хойш 30 хувийг олгохоор буюу автозамын ажилд хяналт хийж эхлээгүй байхад 30 хувь, автозамын ажил 50 хувьтай байхад, хяналтын зөвлөх үйлчилгээний хөлсний 60 хувийг гүйцэтгэгчид олгохоор заасан байна. Гэрээт ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрсний дараа зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан.*

2.29 Энэ нь Төсвийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 24 дүгээр зүйлийн 24.4[33] дэх заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.2[34]-т заасныг тус тус зөрчсөн байх тул зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулсан үйл явцыг хууль хяналтын байгууллагаар шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

[33] Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

[34] "... тендер шалгаруулалтыг зохион байгуулж үнэлэхдээ холбогдох хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж, гаргасан зөрчлийг тухай бүр залруулах"

БҮЛЭГ 3. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮР ДҮНТЭЙ ХЯНАЛТ ТАВИАГҮЙ, ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Концессын зүйлийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гаргасан Засгийн газрын шийдвэрүүд уялдаа холбоогүй, холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын хяналт хангалтгүй байна

3.1 ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын 2.2 дугаар зүйлд: "2.1-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл болон улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Засгийн газарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд" даалгажээ.

3.2 Гэвч дээрх төлөвлөгөөг одоог хүртэл боловсруулж, батлуулаагүй, хэрэгжилтийг УИХ-ын ЭЗБХ-нд тайлагнаагүй байх бөгөөд эдгээртэй холбогдсон ямар нэг шийдвэр гараагүй байна.

3.3 Зохицуулагч болон концесс олгогч байгууллагууд зардал, ашгийн тооцоо хийгдээгүй төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байх, зураг төсөл боловсруулагдаагүйгээс хүчин чадал, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй байх, зураг төслийг зохиох явцад барилгын хийц, материалын сонголтыг хуучирсан, ашиглахад хүндрэлтэй, үр ашиг муутай материалаар хийх, барилгын зарим ажлыг орхигдуулах, зурагт тусгагдсан ажил төсөвт бүрэн тусгагдаагүй зөрчил аудитаар илэрлээ. Тухайлбал,

- *Хүний хөгжлийн төв цогцолбор байгуулах төслийг ТЭЗҮ, зураг төсөл боловсруулагдаагүй байхад хэрэгжүүлэхээр жагсаалтад батлуулснаас 2014 онд гэрээ байгуулагдсан боловч гэрээ хүчин төгөлдөр болоогүй, тодорхой ажил хийгдээгүй, хэрэгжих боломжгүй болсон;*
- *Дундговь аймгийн Сайнцагаан сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төслийн концесс эзэмшигч "Бармон" ХХК гадна шугам сүлжээний угсралт холболтын зураг, төслийг боловсруулаагүй;*
- *Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц барих төслийн барилгын ажлын төсөвт магадлал хийгдээгүйгээс Цагаансуварга-Оюутолгойн 220 кВт-ын хоёр хэлхээт ЦДАШ-ын ажлын материалын зардалд зарим нэр төрлийн барааны үнийг буруу тооцсоноос 5,240.3 сая төгрөгөөр илүү төсөвлөсөн;*
- *Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км авто зам барих төслийн концесс эзэмшигч "Эс Си ЭФ" ХХК-ийн хяналтын төсөвт 8 удаа өөрчлөлт орсон;*
- *Баянхонгор аймгийн Богд суманд баригдсан 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг хуучин барилгатай холбох хүзүүвчний барилга зурагт тусгагдаагүйгээс магадалшгүй ажлын зардлаар гүйцэтгэх санал гаргасан;*
- *Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн барилгыг хуучин сургуулийн барилгатай холбох хүзүүвчийн барилгын ажил зурагт тусгагдаагүй;*
- *Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгоны 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын хяналтын төсөвт хавтгай дээврээс гадна шувуун нуруутай дээврийн ажлыг давхар тусгасан, 6.1 сая төгрөгийн халаалтын зуухны үнийг 17.6 сая төгрөгөөр буюу өндөр үнээр, цутгамал дам нурууны обьёмыг 28.7 м.кв-аар, будах талбайг 953.7 м.кв-аар, нийт 104.2 сая төгрөгийн ажлыг илүү тусгасан;*
- *Даланзадгад-Цогтцэций (Тавантолгой) чиглэлийн 94.8 км хатуу хучилттай авто зам төслийг Цогт-Овоо-Цогтцэций чиглэлийн хатуу хучилтай авто зам гэж чиглэлийг өөрчилсөн;*
- *Засгийн газрын 2016 оны 273 дугаар тогтоолоор "3.1 км сайжруулсан шороон зам, 0.3 км хатуу хучилттай авто зам"нэмж батлагдсаныг Засгийн газрын 2016 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 343 дугаар тогтоолоор 3.4 км хатуу хучилттай авто зам гэж өөрчилсөн байна;*
- *Нийслэлийн Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн барилга Засгийн газрын 317 дугаар тогтоолоор 960 суудалтай байхаар батлагдсан боловч Засгийн газрын 2015 оны 393 дугаар тогтоолоор "зураг төсөл боловсруулах-буулгах-барих-шилжүүлэх" төрлөөр "ӨВМТХ" ХХК-тай гэрээ байгуулах эрх олгож, 1500 суудалтай сургуулийн барилга барих 6.7 сая ам.долларын гэрээ байгуулагдсан бөгөөд хүчин чадлыг нэмэгдүүлсэн үндэслэл тодорхойгүй, эрх бүхий байгууллагаас нэмэгдүүлэх шийдвэр гаргаагүй байна.*

3.4 ҮХГ-ын дарга Б.Баярсайхан Засгийн газрын 2016 оны "Концессын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 37 дугаар тогтоолын 1.1[35], 1.2[36], 1.3[37], 1.4[38]-т заасныг хэрэгжүүлээгүй, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан 686.0 тэрбум төгрөгийн 11 гэрээг цуцлаагүй, концессын "барих-шилжүүлэх" төрлийн 1,050.5 тэрбум төгрөгийн 8 гэрээг шинээр байгуулсан байна. Үүнд:

- *Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төслийн гэрээг "Монголын алт" (МАК) ХХК-тай 2017.01.12-нд;*
- *Өмнөговь аймгийн төвийг Нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам барих ажлын гэрээг "Эн Си Эф" ХХК-тай 2017.03.30-нд;*
- *"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн төслийн гэрээг "Алтай трест" ХХК-тай 2017.03.30-нд;*
- *Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төслийн гэрээг "Шинжиан Шинфа" компанитай 2017.04.12-нд;*
- *Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төслийн гэрээг "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай 2017.03.30-нд;*
- *Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төслийн гэрээг "Хос мөнгөн зам" ХХК-тай 2017.02.03-нд;*
- *Дорноговь аймгийн Сайншанд сум болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам төслийн гэрээг "Засаг чандмань" ХХК-тай 2017.04.12-нд;*
- *Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих төслийн гэрээг "Томо бюлдинг" ХХК-тай 2017.04.13-нд тус тус байгуулсан байна.*

3.5 Гэтэл Засгийн газар дээрх 37 дугаар тогтоол гарсны дараа эдгээр концессын зүйлд гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрүүдийг Засгийн газрын 2016 оны 148, 213, 264, 317, 2017 оны 107, 113, 120 дугаар тогтоолуудаар өмнөх шийдвэрээ үгүйсгэсэн байна.

3.6 Мөн УИХ-ын 2016 оны "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр батлах тухай" 71 дүгээр тогтоолд үндэслэн Засгийн газраас гаргасан 2016 оны 208 дугаар тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-нд эдгээр төслүүдийг 2017 онд багтаан хэрэгжүүлж эхлэхээр заасан, "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулагдсан эдгээр гэрээ нь улсын төсвийн үр ашгийг дээшлүүлэх бус төсөвт ачаалал нэмэгдүүлэх бодит эрсдэлтэй зэргээс харахад Засгийн газраас гаргасан шийдвэрүүд хоорондоо уялдаагүй, харилцан зөрчилдсөн, үндэслэл, тооцоолол хангалтгүй явж ирснийг илтгэж байна.

3.7 2017 оны байдлаар концессын гэрээгээр хэрэгжиж буй нийт 333.3 тэрбум төгрөгийн 22 ТАХ-ний хэрэгжилт дуусаж, гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөл хангагдаагүй шалтгааны улмаас 11,498.6 тэрбум төгрөгийн 17 гэрээ хэрэгжээгүй, бусад 17 гэрээний хэрэгжилт 5-95 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.8 ҮХГ төсөл хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдсан эсэх талаар дүгнэлт гаргаагүйгээс дараах гэрээнүүдийн хувьд гэрээ хүчин төгөлдөр болоогүй байна. Тухайлбал,

Дэд бүтцийн салбар:

- *Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төслийн концессын "барих-шилжүүлэх" төрлийн гэрээг шууд аргаар ХОГ "Ай Эй И" ХХК-тай 2016.07.18-нд (нийт хөрөнгө оруулалт 11.3 тэрбум төгрөг) байгуулж, концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх тухай хүсэлтийг 2 удаа ирүүлсэн ч гэрээ хүчин төгөлдөр болгох дүгнэлт гараагүй.*
- *Сэлэнгэ аймгийн Мандал сумын дулааны төв шугам, дулааны дэд станц, бохирын шугам барих" концессын шууд гэрээ 2016 онд "Бумбод" ХХК-тай байгуулсан боловч концесс эзэмшигч гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлийг хангаагүй тул гэрээ хүчин төгөлдөр болоогүй.*

Авто замын салбар:

- *Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл,*

[35] 1.1-д концессын зүйлийн жагсаалтад "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр тусгасан улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын гэрээг 2018 оны төсвийн жил хүртэл аливаа этгээдтэй байгуулахгүй байх;

[36] 1.2-т улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй, концессын гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх;

[37] 1.3-т концессын гэрээ байгуулах замаар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг шинээр үүсгэхгүй байх;

[38] 1.4-т концессын гэрээ байгуулсан боловч ажил нь эхлээгүй гэрээний үйлчлэлийг зохих журмын дагуу зогсоох.

- *Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл "барих-шилжүүлэх гэрээ,*
- *Дорноговь аймгийн Сайншанд болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам төсөл "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" гэрээ,*

Боловсролын салбар:

- *Дундговь аймгийн Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэгийн барилга барих төслийн концессын гэрээг ҮХГ "Бармон"ХХК-тай 2016.06.24-ны өдөр (нийт хөрөнгө оруулалт 3.3 тэрбум төгрөг) байгуулж, гэрээний 1.12-т заасан гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл хангагдаагүй, Засгийн газрын 2017.02.01-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлээр "төсөвт өртгийг дахин нягталсны дараа гэрээг хүчин төгөлдөр болгох" гэж заасныг хэрэгжүүлээгүйн улмаас гэрээ хүчин төгөлдөр болоогүй.*
- *Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих төсөл,*
- *Баянхонгор аймгийн Баянговь суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих төсөл зэргийг дурдаж болохоор байна.*

3.9 Концессын зүйлийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг боловсрол, эрүүл мэнд, эрчим хүчний салбарын хувьд Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай гэрээ байгуулан, бусад салбарын хувьд зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж байна.

3.10 Концесс олгогч ҮХГ нь зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, зохиогчийн хяналтын үр дүнг үнэлсэн дүгнэлт гаргалгүйгээр санхүүжилтийг олгосон нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4[39]-т заасныг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалсан байна. Тухайлбал,

Захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй:

- *"Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төслийн концессын "барих-ашиглах-шилжүүлэх" төрлийн концессын гэрээний 2.5-т "... концессын зүйлийг ашиглалтад оруулах хугацааг 2017.11.15-ны өдрөөс өмнө"... заасан хугацаанд техникийн нөхцөл болон барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл сунгагдаагүй, дуусаагүй барилгыг хүлээн авснаас хойш ажлын гүйцэтгэл гараагүй, концесс олгогчоос хяналт тавиагүй байна. ҮХГ уг төсөлд техник хяналт тавих зөвлөхийн гэрээг холбогдох мэргэжлийн байгууллагатай байгуулаагүй, төслийн ажил 2017.10.31-ны байдлаар ямар шатанд байгаа талаар ямар нэгэн мэдээлэлгүй байна.*

Зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй:

- *Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төслийг гүйцэтгэгч "Наранбулаг" ХХК-ийн ажлын гүйцэтгэлд зохиогчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй боловч зохиогчийн хяналт хийсэн тухай дүгнэлтийг 2016 оны 09 дүгээр сарын 06-нд гаргасан бөгөөд уг дүгнэлтэд ажлын тоо хэмжээний өөрчлөлт тусгагдаагүй, хяналт хийгдээгүй.*

Зохиогчийн хяналтын тайланд хяналт, шинжилгээ хийлгүйгээр санхүүжилт олгосон:

- *"Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн 220 кв-ын хоёр хэлхээт ЦДАШ, дэд станц" төсөлд ҮХГ, "Монголын алт" ХХК, "Баясал төгс" ХХК-тай 2017.06.30-ны өдөр ҮХГ/15 355-2117 дугаартай зохиогчийн хяналтын гурван талт гэрээг (гэрээний дүн 33.1 сая төгрөг) байгуулж, гэрээний 2.1-т заасны дагуу "Баясал төгс" ХХК нь 2017.07.04-ны өдрийн 17/611 тоот албан бичгээр ҮХГ-т зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн ч ҮХГ зохиогчийн хяналтын үр дүнд хяналт-шинжилгээ хийлгүйгээр 2017.10.09-ны өдөр 30.0 сая төгрөгийг,*
- *"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт" төсөлд ҮХГ, "Алтай трест" ХХК, "Баясал төгс" ХХК-тай 2017.06.30-ны өдөр ҮХГ/16 дугаартай зохиогчийн хяналт хийх 3 талт гэрээг (гэрээний дүн 363.1 сая төгрөг) байгуулж, "Баясал төгс" ХХК нь 2017.09.14-ны өдрийн 17/908 тоот албан бичгээр ҮХГ-т зохиогчийн хяналтын тайланг 1 удаа хүргүүлсэн, ҮХГ гэрээний 4.1 ажлын гүйцэтгэлийг тухай бүр шалгаж хяналт тавих эрхтэй... гэсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, зохиогчийн хяналтын үр дүнд хяналт-шинжилгээ хийлгүйгээр 2017.08.30-ны өдөр 72.6 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.*

3.11 Боловсролын салбарын хувьд Барилгын хөгжлийн төв нь ҮХГ-тай байгуулсан гэрээний дагуу 2016 оны 12 дугаар сараас эхлэн барилгын захиалагчийн хяналтыг гүйцэтгэж эхэлсэн бөгөөд түүнээс өмнө аймгуудын ГХБХБГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ирсэн гэх боловч захиалагчид тайланг хүргүүлээгүй, хяналт хэрэгжүүлснийг нотлох хангалттай баримт байхгүй байна.

3.12 Боловсролын салбарын төслүүдэд захиалагчийн хяналт иж бүрэн хэрэгжээгүй нь ХОГ (хуучин нэрээр) нь ҮХГ болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан, концессын гэрээний дагуу

[39] барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ ... гэрээг байгуулж ажиллах.

захиалагчийн хяналтын зардлыг ҮХГ-т газарт төвлөрүүлэхэд тодорхой хугацаа шаардагдсанаас шалтгаалсан байна. Тухайлбал,

- *Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Жаргалант сумдад баригдсан 150 ортой цэцэрлэгийн барилгын ажилд аймгийн ГХБХБГ захиалагчийн хяналт тавих ёстой байсан боловч барилгыг ашиглалтад орсны дараа 2 удаа барилга, угсралтын ажилтай танилцсан нь барилгын ажлын үе шат бүрд хийгдэх хяналт иж бүрэн хийгдээгүй харуулж байна.*
- *Хөвсгөл аймгийн Жаргалант сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, угсралтын ажлын гүйцэтгэлд БХТ-өөс хяналт хийхдээ зураг төсөвт заагдсан зарим ажил хийгдээгүй, нэмэлтээр хийгдсэн зураг, төсөвт өөрчлөлт оруулж баталгаажуулаагүй, зохиогчтой зөвшилцөөгүй байхад 28.7 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг нэмж баталгаажуулсан.*
- *Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багт баригдсан 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, угсралтын ажлын зарим ил далд ажлын актыг үйлдэж, баталгаажуулаагүй, фото зургаар баримтжуулаагүй, барилга, угсралтын ажлыг зургаас өөрчлөн гүйцэтгэсэн боловч зургийн өөрчлөлтөд магадлал хийгдээгүй, магадалшгүй ажлын актыг захиалагч баталгаажуулаагүй, захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй байна.*

3.13 Эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа төслүүдэд тавих техникийн хяналтыг Эрчим хүчний хөгжлийн төв хэрэгжүүлэхдээ концесс олгогчид ирүүлсэн тайланд барилгын ажлын гүйцэтгэл, чанар байдалд хэрхэн үнэлгээ өгч баталгаажуулсан, зөвлөмж чиглэл өгсөн эсэх нь тодорхойгүй, ажлын чанар, үр дүнг илтгэсэн тайланг гаргаж бэлтгээгүй байна. Тухайлбал,

- *"Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн 220 кВт-ын хоёр хэлхээт ЦДАШ, дэд станц"-ын барилга, угсралтын ажлын явцад техник хяналт тавих гэрээг 2017.03.03-ны өдөр байгуулж, гэрээний 2.2.14[40], 2.3[41]-т зааснаар төслийн барилга, угсралтын ажлын явцад хяналт хийсэн тайланг ҮХГ-т 5 удаа гаргаж хүргүүлэхдээ ажлын тайланг зургаар илэрхийлж, барилгын ажлын явц, гүйцэтгэлийг хувиар тайлагнасан ч ажлын чанар байдалд үнэлгээ өгч баталгаажуулаагүй.*
- *"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт" төслийн барилга, угсралтын ажлын явцад техник хяналт тавих гэрээг 2017.06.15-ны өдөр байгуулж, төслийн барилга, угсралтын ажлын талбайд 2017.07.01-2017.09.08 хооронд 4 удаа ажилласан талаарх нэгтгэсэн тайланг ҮХГ-т хүргүүлсэн ч, ажлын гүйцэтгэлийн тоо хэмжээ, ажлын чанарыг баталгаажуулсан тайланг хүргүүлээгүй.*

3.14 Концессын олгогч гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавиагүй, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, салбарын яамдын ажлын уялдаа, зохион байгуулалт, хариуцлагагүй байдлаас шалтгаалан зарим концессын төсөл зогсонги байдалд орсон, зарим төслийн гэрээлэгч талууд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

Эрчим хүчний салбар:

- *"Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн ЦДАШ, дэд станц" төслийн концессын гэрээ байгуулагдах хүртэлх хугацаанд "төслийн ажлын гүйцэтгэл 45 хувьтай, концесс эзэмшигч 11.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн" гэж тодорхойлсон боловч концесс олгогч тооцооллыг хянаагүй, акт үйлдээгүй,*
- *"Багануурын цахилгаан станц" төслийн 897.6 сая ам.долларын хяналтын төсвийг хэн зохиосон нь тодорхойгүй, магадлал хийгдээгүй байна. Гэрээний 3.13-т зааснаар концесс эзэмшигч концесс олгогчид 3.0 сая ам.долларын концессын төлбөрийг 5 хэсэгт хуваах хуваарийн дагуу төлөх эхний (1) санхүүгийн хаалтын дараа 600.000 ам.долларыг 2016 оны 10 дугаар сард ЭХХТ-ийн дансанд шилжүүлсэн нь гэрээний 3.13.1-д "концессын төлбөрийг эрх бүхий этгээдийн нэрлэсэн дансанд төлнө" гэсэн үүргээ хэрэгжүүлээгүй, ҮХГ-ын дансанд төлбөрийг төвлөрүүлээгүй зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд холбогдох асуудлыг хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй байна.*

Дэд бүтцийн салбар:

- *"Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төслийн концессын "барих-ашиглах-шилжүүлэх" төрлийн гэрээг "Ай Эй И" ХХК-тай 2016.07.18-ны өдөр байгуулж, гэрээний 2.5-т "концессын зүйлийг ашиглалтад оруулах хугацааг 2017.11.15-ны өдрөөс өмнө" гэж заасан боловч ажил эхлээгүй байна.*

Авто замын салбар:

- *Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл: ЗТЯ (хуучин нэрээр) нь 2012 онд "Эрдэнэ зам" ХХК-тай гэрээ байгуулсан боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй тул уг төсөл хэрэгжээгүй байна. Дээрх гэрээг цуцлаагүй байхад ЭЗХЯ (хуучин нэрээр)-аас уг төслийг Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор концессын зүйлийн жагсаалтад нэмж 2015 онд уралдаант шалгаруулалтаар "ЭХБУТ" ХХК шалгарч концессын гэрээ байгуулсан боловч "Эрдэнэ зам" ХХК "2012 онд байгуулсан гэрээг цуцлаагүй байхад концессын гэрээ байгуулсныг хүчингүй болгуулах тухай" нэхэмжлэл шүүхэд гаргаснаар авто замын барилга угсралтын ажил зогсжээ. "Эрдэнэ зам"*

[40] Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн мэдээг гаргаж, эрчим хүчний салбарын төрийн захиргааны төв байгууллага олон эрх бүхий этгээдэд тухай бүр хүргүүлэх үүрэгтэй.

[41] ЭХХТ нь энэхүү гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлаа эрх бүхий этгээдийн өмнө хариуцан тайлагнах бөгөөд Концесс эзэмшигчийн гарсан гүйцэтгэлийн тоо хэмжээ, ажлын чанарыг баталгаажуулж, эрх бүхий этгээдэд тухай бүр хүргүүлнэ.

ХХК нь шүүхэд гаргасан нэхэмжлэлээ татан авсан тул Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017.06.27-ны өдрийн 181/Ш32017/09403 дугаар захирамжаар хэрэгсэхгүй болгож, "ЭХБУТ" ХХК-аас "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, барилгын ажлын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталгаажуулах тухай" хүсэлтийг 2017.08.09-нд албан бичгээр ЗТХЯ болон ҮХГ-т хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.

3.15 Концессын төслийг эзэмшигч ААН-үүдийн гаргасан ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс аудитын явцад концессын зарим төслүүдийн хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийсэн шалгалтаар нийт 8 концессын төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд ажлын тоо хэмжээ, нэгжийн үнэлгээг буруу тооцсоноос 1,047.8 сая төгрөгийн зөрүүг хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөөс суутган тооцохоор ҮАГ-аас шийдвэрлэсэн. Үүнд:

- *Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэлийн төсөвт 27.5 сая төгрөгийн ажлыг илүү, 28.5 сая төгрөгийн ажлыг дутуу тусгасан.*
- *Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян-Ойт багийн 100 ортой 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэгч "Зүүн шанд" ХХК-ийн гүйцэтгэлийн төсөвт 27.5 сая төгрөгийн ажлыг илүү, 22.0 сая төгрөгийн ажлыг дутуу тусгасан;*
- *Баянхонгор аймгийн Богд суманд баригдсан 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэгч "Жишиг бетон" ХХК-ийн гүйцэтгэлийн төсөвт 25.5 сая төгрөгийн ажлыг илүү, хайрганы тээврийн зардлыг 9.6 сая төгрөгөөр дутуу тусгасан;*
- *Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгоны 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгч "Очир заан" ХХК-ийн гүйцэтгэлийн төсөвт ажлын тоо хэмжээний зөрүүгээс 9.1 сая төгрөгөөр илүү тооцсон, 17.8 сая төгрөгийн магадалшгүй ажлын акт үйлдээгүй;*
- *Нийслэлийн Баянгол дүүргийн 73 сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгч "Монкон констракшн" ХХК-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд материалын сонголтыг буруу хийсэн, машин механизм, цалин, тээврийн зардлыг норматив үнэлгээнээс илүү үнэлгээгээр үнэлснээс шалтгаалж нийт 282.5 сая төгрөгийг илүү тусгасан;*
- *Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар сургууль барих төслийн концесс эзэмшигч "Ганьт" ХХК барилга угсралтын ажлын гүйцэтгэлд зарим ажлын тоо хэмжээ, зураг, төсөлд оруулсан өөрчлөлтөөс үүссэн ажлын тоо хэмжээг алдаатай тооцсоноос ажлын бодит гүйцэтгэл 62.6 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн,*
- *Нийслэлийн Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн барилга барих концесс эзэмшигч "ӨВМТХ" ХХК ажлын гүйцэтгэлд ажлын тоо хэмжээ, механизмын зардлыг давхардуулан тооцож, 502.1 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,*
- *Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн барилга барих концессыг хэрэгжүүлэгч "Цамхаг констракшн" ХХК барилга угсралтын ажлын тоо хэмжээ, үнэлгээг буруу тооцсоноос 153.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг илүү тооцож, баталгаажуулсныг аудитаар эргэн төлөлтийн санхүүжилтээс суутган тооцохоор шийдвэрлэсэн.*

Салбарын яам концесс олгогч, концесс эзэмшигч нарын зөвшөөрөлгүйгээр төслийн нэгж байгуулж, хяналтыг давхардуулан хэрэгжүүлж, үргүй зардал гаргажээ

3.16 Концессын "барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа дараах төсөлд ЭХЯ-аас техник хяналтын гэрээ байгуулахдаа ҮХГ-ыг оролцуулаагүй, төслийн нэгжийг байгуулахдаа концесс олгогч, эзэмшигчтэй зөвшилцөөгүйгээс техник хяналт тавих чиг үүргийг 2 байгууллага давхардуулан хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- *"Багануур цахилгаан станц" төслийн концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдээр гэрээнд ҮХГ, ЭХЯ, ЭХЗХ байхаар заасан ч төслийн барилга, угсралтын ажлын явцад техник хяналт тавих гэрээнд концесс олгогч оролцоогүй, зөвхөн ЭХХТ, "Багануур Пауэр" ХХК-ийн хооронд 2017.06.13-ны өдрийн ЭХХТ/56/2017 дугаартай гэрээг байгуулсан.*
- *ЭХХТ нь "Багануурын 700 мВт хүчин чадалтай цахилгаан станц"-ын барилга, угсралтын ажлын явцад техник хяналтыг 2017.08.17, 2017.08.22-нд хийж, үүрэг даалгавар, 2017.08.24-нд 1/749 дугаар албан шаардлага "Багануур Пауэр" ХХК-д тус тус өгчээ.*
- *ЭХС-ын 2016 оны 10 дугаар тушаалаар "Багануур цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, концессын гэрээний 3.11.2[42]-т заасныг хэрэгжүүлэх үүрэгтэй гэж тодорхойлсон боловч концесс олгогч, концесс эзэмшигчтэй зөвшилцөөгүй, "Багануур Пауэр" ХХК-тай хяналтын гэрээ байгуулаагүй байна. Төслийн нэгж нь уг төслийн барилга, угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт хийж байгаа нь ЭХХТ-ийн техникийн хяналттай давхардаж байна.*

[42] "... концесс олгогч болон концесс эзэмшигч нь хамтран төслийн хэрэгжилтэд хяналт тавих мэргэжлийн өндөр ур чадвартай бие даасан инженер томилон ажиллуулах ба концесс эзэмшигч нь бие даасан инженертэй хяналтын гэрээ байгуулж ажиллана"

3.17 Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авахдаа барилгын чанар, аюулгүй байдалд гүйцэтгэгчээр баталгаа гаргуулаагүй, зарим ил далд ажил, тоног төхөөрөмжид туршилт хийсэн акт үйлдэгдээгүй байхад ашиглалтад хүлээн авчээ. Тухайлбал,

- *2017.08.15-нд ашиглалтад оруулсан Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд баригдсан 150 ортой цэцэрлэгийн барилга,*
- *2016.11.18-нд ашиглалтад оруулсан Хөвсгөл аймгийн Жаргалант суманд баригдсан 150 ортой цэцэрлэгийн барилга,*
- *2017.01.13-нд ашиглалтад оруулсан Дархан-Уул аймгийн Дархан суманд баригдсан 100 ортой цэцэрлэгийн барилга.*

3.18 Концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд ҮХГ-ын ХШҮДАГ-аас хяналт шалгалтыг 2016 оны 10 дугаар сард хийжээ. Уг шалгалтаар "*концессын төслүүдийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй, гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөлийг хянаж дүгнэлт гаргаагүй*" зэрэг зөрчлүүд илэрсэн бөгөөд үүний дагуу зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд цэгцлэгдээгүй орхигдсон баримтуудыг архивын нэгж болгосон байна.

3.19 ҮХГ-ын ТХХТ-ийн албаны зүгээс концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийн явцтай биечлэн танилцаж, хяналт тавиагүй нь байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхаас шалтгаалсан байна.

3.20 Концессын төслүүдэд захиалагчийн хяналт бүрэн хэрэгжихгүй байгаа төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, ҮХГ-т хяналт тавих мэргэжлийн боловсон хүчин дутмаг байгаатай холбоотой байна.

3.21 Түүнчлэн концессын гэрээгээр баригдаж ашиглалтад хүлээн авсан төслүүдийн үр өгөөжийг тооцсон, тэдгээрийн гүйцэтгэлийн чанар, байдалд үнэлгээ хийсэн баримт, мэдээлэл ҮХГ-т байхгүй байна.

Концесс эзэмшигчид хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлэхэд хугацаа алдаж байгаа нь концессын төслүүд хугацаандаа хэрэгжихгүй байх шалтгаан болж байна

3.22 Концессын гэрээгээр ажил гүйцэтгүүлэх нэг давуу тал нь төрийн хувьд концесс эзэмшигчид өөрийн болон өөрийн боломжоор олсон санхүүгийн хөрөнгийн эх үүсвэрээ бүрдүүлсэн тохиолдолд хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, зээлийн хүүгийн дарамтад орохгүйн тул харьцангуй богино хугацаанд барилга, байгууламжийг барьж ашиглалтад оруулах явдал болж байна.

3.23 Гэвч концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцийн өөрчлөлт, концесс эзэмшигчийн ажлын зохион байгуулалт, чадавх зэргээс шалтгаалан концессын гэрээгээр баригдаж буй зарим авто зам, сургууль, цэцэрлэгийн барилга угсралтын ажил баталсан хуваарийн дагуу хугацаандаа баригдахгүй, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ашиглалтад хүлээлгэн өгөх хугацааг сунгах тохиолдол цөөнгүй гарч байгаа нь концессын төслийн үр ашгийг бууруулах хүчин зүйл болж байна. Тухайлбал,

- *Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төслийг гүйцэтгэгч "Наранбулаг" ХХК-ийн ажил төлөвлөсөн хугацаанаас 8 сараар хоцорсон төдийгүй 79.9 сая төгрөгийн ажлыг зураг, төсөвт тусгагдсанаас дутуу хийсэн;*
- *Хөвсгөл аймгийн Галт сумын Идэрийн голын хөвдөг гүүр барих төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг "зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан боловч гүүрийн ажлыг гэрээт хугацаанаас 1 жилийн дараа ашиглалтад хүлээлгэн өгсөн;*
- *Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян-Ойт багийн 1-р цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга барих ажлыг 2016 оны 11 дүгээр сарын 1-ний дотор бүрэн барьж дуусган, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр "2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор бүрэн барьж дуусган ашиглалтад хүлээлгэн өгнө ..." гэж сунгасан,*
- *Баянхонгор аймгийн Богд суманд баригдах 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих ажлыг 2016 оны 11 дүгээр сарын 1-ний дотор бүрэн барьж дуусган, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр "2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн барьж дуусган ашиглалтад хүлээлгэн өгнө ..." гэж сунгасан,*

- *Нийслэлийн Баянгол дүүргийн 38 дугаар сургуулийн барилгын зураг төслийг "Нутгийн босго" ХХК боловсруулж, магадлал хийлгэхэд хугацаа алдсанаас гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа 4 сараар хойшилсон байна.*

3.24 Концесс эзэмшигчид ихэнхдээ концессын гэрээний урьдчилсан нөхцөлийг хангахад хугацаа алдаж байгаа нь дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд санхүүжилтийн эх үүсвэр олоход бэрхшээлтэй байдаг, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьд төслийн зардал, ашгийн тооцоолол хийх, хөрөнгө оруулалтаас олох ашиг тодорхойгүй байдагтай холбоотой байна.

Гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг зөвхөн барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй уялдуулж байгаа нь эрсдэлтэй байна

3.25 ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтсийн бүтцэд судалгаа, шинжилгээ хариуцсан алба ажиллаж байгаа боловч концессын төслүүдээс Монгол Улсын эдийн засаг, нийгмийн болон улсын төсвийн хэтийн төлөв байдалд үзүүлэх нөлөөлөл, гарах үр дүнгийн талаар судалгаа шинжилгээ хийгээгүй байна.

3.26 Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр байгуулсан төслүүдийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарийг улсын төсвийн төлөвлөлттэй уялдуулж, тусгаагүйгээс ТАХ-ний санхүүжилт хугацаандаа олгогдохгүй концесс эзэмшигч эрсдэлд орох, концесс олгогч алданги, торгууль зэрэг санхүүгийн нэмэлт зардал гарах эрсдэлтэй байна. (*Дэлгэрэнгүйг хавсралт №3)*

3.27 Тухайлбал, улсын төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан концессын гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2017 онд санхүүжилтийг бүрэн олгож чадаагүй, 2018 оны төсвийн төсөлд бүрэн тусгаагүйгээс Алтай-Дарви чиглэлийн 265 км авто замын төсөл "Лунзянь бридж констракшн" ХХК-д алданги төлөх нөхцөл байдал үүсээд байна. "Лунзянь бридж констракшн" ХХК-ийн 2017 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн албан бичгээр концессын гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу эргэн төлөлтийг хийж чадаагүй, эргэн төлөлт 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хойшилсноос үүсэх нийт алдангийн хэмжээ 11.1 сая юаньд хүрээд байгаа тухай мэдэгдсэн байна.

3.28 Мөн Сангийн яам, ҮХГ хооронд концессын өрийг бүртгэх, эргэн төлөлт хийх, төсвийн ачаалалтай нийцүүлж эргэн төлөлтийн хуваарийг гэрээнд тусгах тал дээр үр дүнтэй хамтын ажиллагаа хөгжүүлээгүй байна.

3.29 Концессын гэрээний эргэн төлөлтийг улсын төсвөөс олгохдоо гэрээнд заагдаагүй санхүүжилтийг нэмэлт өөрчлөлтөөр гэрээнд тусгаж, гүйцэтгэсэн ажлын бодит хөрөнгө оруулалтын тооцооллыг хийж баталгаажуулалгүйгээр ажлын гүйцэтгэлээс илүү дүнгээр санхүүжилт олгосон зэрэг нь Концессын тухай хуулийн 4.1.2-т "*...концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал,

Гүйцэтгэсэн ажлын хэмжээнээс илүү санхүүжилт олгосон:

- *Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын автозамтай холбох 95 км хатуу хучилттай авто замын эхний ээлжийн 25 км замыг ашиглалтад оруулж, хийгдсэн ажлын гүйцэтгэл гэрээний дүнгийн 27 хувьд хүрээгүй байхад 57.2 тэрбум буюу нийт гэрээний үнийн дүнгийн 70.3 хувийг олгосон байна.*

Концессын "барих-шилжүүлэх" төрлийн үндсэн зарчмыг алдагдуулж, ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгохоор гэрээ байгуулсан:

- *Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Ганьт" ХХК-тай 2016.05.19-нд байгуулсан гэрээнд ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэж, түүнд ногдох 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тухайн онд олгохоор тусгасан,*
- *Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Цамхаг констракшн" ХХК-тай 2016.06.14-нд байгуулсан гэрээнд ажлын гүйцэтгэлийг 2016 онд 30 хувьд хүргэн, түүнд ногдох 2.9 тэрбум төгрөгийг тухайн онд санхүүжүүлэхээр тусгасан байна.*

3.30 УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт "*улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг*

түр хойшлуулах” гэж заасны дагуу ҮАГ-аас концессын төслүүдэд дүгнэлт гаргахад тодорхой хугацаа шаардагдаж байгаа тул концесс эзэмшигчид улсын төсвөөс санхүүжилт авахад цаг хугацааны хувьд эрсдэлтэй нөхцөл байдал бий болсон байна.

3.31 Түүнчлэн Сангийн яам, ҮХГ нь УИХ-ын дээрх тогтоолыг зөрчиж дараах төслүүдийн санхүүжилтийг аудитын дүгнэлт гараагүй байхад олгожээ. Үүнд:

- *Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар дунд сургуулийн БУА-ын НХОГ-аас баталгаажуулсан 50 хувийн гүйцэтгэлд үндэслэн нийт төсөвт өртгийн 50 хувь буюу 2,900.0 сая төгрөгийг “Ганьт” ХХК-д 2017.07.06-ны өдөр,*
- *Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн БУА-ыг гүйцэтгэгч “Цамхаг констракшн” ХХК-д ажлын 30 хувийн гүйцэтгэлийг үндэслэн 2,900.0 сая төгрөгийг 2017.08.30-нд,*
- *Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто зам барих ажлын гүйцэтгэгч “Хансуун зам” ХХК-ийн 2018.02.13-14-ний өдрүүдэд 2,165.8 сая,төгрөг, нийт 7,965.8 сая төгрөгийг тус тус олгосон байна.*

Барилга байгууламжийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаатай холбоотой үүрэг, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаагүйгээс ашиглагч байгууллагын хэрэгцээг бүрэн хангахгүй байна

3.32 Концессын зүйлийг ашиглагч зарим байгууллагаас БУА-ын гүйцэтгэлтэй холбоотой дутуу орхигдсон, чанаргүй хийгдсэн ажлууд байгаа талаар мэдээлэл ирүүлж байна. Тухайлбал,

- *Нийслэлийн 73 дугаар сургуулийн захиргаанаас барилгын ажил 2017.09.15-нд ашиглалтад орсон боловч дээврээс ус гоожсон, цонхны амалгаа, салхивчны резин дутуу хийгдсэнээс дулааны алдагдал гарч байсан,*
- *Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн БУА-ыг “Ганьт” ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сард улсын комисс хүлээн авч, хүйтний улирал эхэлснээс шалтгаалан гадна тохижилт, ногоон байгууламж, “В” блокны барилгын дээврийн ажил, дотоод заслын ажлууд хийгдээгүй дутуу байна.*
- *Баянхонгор аймгийн төвийн 6 дугаар цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Зүүн шанд” ХХК барилгын ажлыг гүйцэтгэхдээ дээврийн дулаалгын үнсээр хийснээс ачаалал ихдэж барилгын дээврийн 3 хэсэгт хотойлт үүсэж, нэмэлт бэхэлгээ тулгуур хийгдсэн байх тул мэргэжлийн байгууллагаар хучилтын төмөр бетон хийц, арматурчлалын бат бөхийг шалгуулж дүгнэлт гаргах шаардлагатай байна.*
- *Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох ажлыг 2012.12.04-ны өдрийн 05/2016 дугаар улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан боловч тус аймгийн Худалдааны чөлөөт бүсийн захирагчийн албанаас 2015.12.23-нд 01/305 дугаар албан бичгээр 3 нэр төрлийн ажлын гүйцэтгэл дутуу байгааг дуусгах талаар мэдэгдсэн боловч хийгдээгүй.*
- *Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгоны 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Очир заан” ХХК барилгын ажлыг 2017 оны 12 дугаар сард ашиглалтад өгсөн бөгөөд хүйтний улирал эхэлснээс шалтгаалан улсын комиссоос үүрэг болгосон 8.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй.*
- *Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам төсөл, "Алтай-Дарви” чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл Байнгын ашиглалтад оруулах комиссын актыг 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр үйлдсэн боловч комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар бүрэн хэрэгжүүлээгүй байна.*

3.33 Концессын “*барих-шилжүүлэх*” төрлөөр хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд олгох санхүүжилтийн хуваарийг концессын зүйлийг хэрэгжүүлж, хүлээлгэн өгөх хугацаатай давхцуулан төлөвлөж, гэрээнд тусгаж байгаагаас концесс эзэмшигчид санхүүжилтээ батлагдсан хугацаанд авахын тулд улсын комисст ажлын гүйцэтгэлийг хүйтний буюу тохиромжгүй улиралд хүлээлгэн өгөх, комиссоос өгсөн үүрэг, даалгавар хугацаандаа хэрэгжих боломжгүй болох сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Ашиглалтад орсон концессын зүйлүүдийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг бүрэн тодорхойлоогүй байна

3.34 Тайлант хугацаанд концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж дуусан нийт 22 төслийн 60.0 хувь буюу 63.7 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 13 сургууль, цэцэрлэг боловсролын салбарт хэрэгжиж ашиглалтад орсноор ерөнхий боловсролын сургуулийн суудал 4060, хүүхдийн цэцэрлэгийн ор 1225-аар нэмэгдсэн байна.

3.35 Сургууль, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо нэмэгдэх, эрүүл аюулгүй орчинд суралцах боломж бий болох, сургалтын орчин сайжрах зэрэг дэвшилтэт үр дүн гарч буй хэдий ч үр ашиг,

чанарын ахиц дэвшлийг хэмжигдэхүйц байдлаар зохистой тоон үзүүлэлтээр нарийвчлан тооцон төлөвлөж, бүртгэж тайлагнах талаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил хангалтгүй байна.

3.36 Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн авто замыг “барих-ашиглах-шилжүүлэх” гэрээг “Ар Ди Си Си” ХХК-тай 2011 онд байгуулж, 2014 онд анхны хүнд даацын 43.2 км авто зам ашиглалтад орсноор шороон замаар тээвэрлэж байсан нүүрсний тээвэрлэлтийг зогсоох байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа болжээ. Концессын гэрээг анх 17 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд төслийн зардал, ашгийн тооцооллыг 1 тонн нүүрсийг 1500 төгрөгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгуулсан боловч одоогийн байдлаар 16 компанитай гэрээ байгуулахаас 2 компани гэрээ байгуулж, бусад нь гэрээ байгуулаагүй, шороон замаар тээвэрлэлт хийсэн хэвээр байгаагаас концесс эзэмшигч ашиггүй ажиллах болсон тул 1 тонн нүүрсийг тээвэрлэх үнийг 1300-аас 800 төгрөг болгон бууруулж, гэрээний хугацааг 30 жил болгон сунгасан байна. Иймд Засгийн газар нүүрс олборлогч, тээвэрлэгч, борлуулагч нарын үйл ажиллагаанд зохицуулалт хийж, хүнд даацын зориулалтын автозамаар нүүрс тээвэрлэлт хийх шаардлагыг тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллах нь зүйтэй байна.

3.37 Концессын гэрээгээр баригдаж, ашиглалтад орсон ихэнх сургууль, цэцэрлэгүүдийн хувьд багш, ажилчдын орон тоо, төсөв нэмэгдэж батлагдсан боловч тавилга, техник хэрэгслийг бэлтгэж нийлүүлэх ажлыг хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулаагүйгээс хүрэлцээ муутай байх эсвэл байршлыг оновчтой сонгоогүйгээс анги дүүргэлт хангагдахгүй байх хандлагатай байна. Тухайлбал,

- *Нийслэлийн Баянгол дүүргийн 73 дугаар сургуулийн хуучин барилга 470 хүүхдийн хүчин чадалтай байсан бөгөөд 960 суудалтай сургууль ашиглалтад орж багш, ажилчдын орон тоо 15-аар нэмэгдсэн ч 8 ангид сурагчийн ширээ, сандал, 21 ангид багшийн ширээ, сандал, шүүгээ дутагдалтай, бага, дунд, ахлах ангийн багш нарт ажлын өрөө шаардлагатай байна.*
- *Нийслэлийн Баянгол дүүргийн 38 дугаар сургууль хуучин тусдаа спорт заалны барилгатай боловч шинээр орсон сургуулийг спорт заалтай бариулсан. Мөн шинээр анги танхимууд нэмэгдсэнээс ширээ, сандал хүрэлцээ муутай байгаа ч одоогоор нэг ээлжээр хичээллэж хүүхдийн тоо хүчин чадалдаа хүрээгүй тул хүндрэл үүсээгүй, харин хүчин чадлаар анги дүүргэлт хийх үед тавилга, техник хэрэгсэл хүрэлцэхээргүй тооцоо гарч байна. Мөн 38 дугаар сургуулийн байршлыг суурьшлын хүн амын тоо, сургуулиудын байршилтай уялдуулаагүйгээс ойрхон 20 дугаар дунд сургууль байршдаг, 1500 хүүхдийн хүчин чадалтай боловч нэг ангид 20-25 хүүхэдтэй нэг ээлжээр хичээллэж байна.*

3.38 Энэ нь концесс хэрэгжүүлэгч байгууллага болон холбогдох салбарын яамдын ажлын уялдаа, хамтын ажиллагаа, төлөвлөлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, аргачлал, маягтыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар идэвх, санаачилга гаргаагүй, Засгийн газрын зүгээс нэгдсэн бодлого зохицуулалтаар хангаагүйгээс концессын зүйлийг төлөвлөж, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт дутагдалтай, концессын зүйлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, мэдээллийн ил тод, иж бүрэн, найдвартай байдал хангагдаагүй байна.

2. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нийгэм, эдийн засагт үзүүлэх үр ашгийн тооцооллыг хийгээгүй, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, бодлогын баримт бичиг, тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдаагүй, хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэгдээгүй хэт олон төслийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

3. Концессын тухай хууль хэрэгжсэн 7 жилийн хугацаанд төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтад 5 удаа өөрчлөлт орж, хариуцлагын тогтолцоо бэхжээгүй, боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, чиг үүргийг хэрэгжүүлэх боловсон хүчин мэргэших, чадавхжих боломж алдагдсан байна.

4. Засгийн газар концессын зүйлийг хэрэгжүүлэх хугацаа, стратегийг тодорхойлоогүй, зайлшгүй шаардлагатай нөхцөл үүсээгүй байхад төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан арга хэмжээний 51.2 хувьд шууд гэрээ байгуулахаар баталж, хууль, тогтоомжийг зөрчсөн байна.

5. Концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах журам шаардлага хангахгүй байгаагаас гэрээ байгуулахдаа Засгийн газар гарч болох эрсдэлийг өөртөө бүрэн үүрч, концесс эзэмшигчийн санхүүжилтийн зардал буюу зээлийн хүү, менежментийн зардалд шалгуур, хязгаар тогтоолгүй концессын зүйлийн өртөгт оруулан тооцсоноос концессын зүйлийн өртөг улсын төсвийн санхүүжилтээр баригдсан ижил төстэй барилга, байгууламжийн төсөвт өртгөөс өндөр байна.

6. Нийт концессын зүйлийн 74.6 хувийг “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа нь олон улсын нийтлэг хандлагаас зөрүүтэй, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнээс онцлог ялгаа бага, урт хугацаанд үр, ашиг өгөхөөргүй байна.

7. Барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлж байгаа концессын гэрээний эргэн төлөлтийн хуваарийг зөвхөн барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй уялдуулан тооцож, төсвийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдуулахгүй байгаагаас шалтгаалж, төсөвт дарамт, ачаалал үүсэж болзошгүй байна.

8. Концессын зүйлийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо, хариуцлагын механизм бүрдээгүй, захиалагч болон зохиогчийн хяналт бүрэн хэрэгжээгүйгээс төслүүдийн хэрэгжилт удаашралтай байна.

9. Концессын гэрээгээр бодлогын зорилт, хуулийн зарчим, агуулгад нийцээгүй 268.2 тэрбум төгрөгийн шууд хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилд хийсэн, нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс давсан, автозамын хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх 9 гэрээг Аж үйлдвэрийн сайдын удирдамжийг үндэслэн байгуулсан зэрэг хууль зөрчсөн үйлдлийг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны анхааралд толилуулах нь:

- Концессын зүйлийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйгээс эдийн засагт үзүүлэх үр нөлөө бага, хэрэгжилтэд тавих хяналт сул, эрсдэл өндөр байгааг харгалзан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг сайжруулах, цаашид концессын "барих-шилжүүлэх" төрлийг ашиглах эсэхийг хянан үзэх.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх-д:

- Концессын зүйлийн жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг, улсын төсөв болон нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, ач холбогдлыг дахин үнэлж, хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн шинэчлэх,
- Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангуулах, боловсон хүчнийг мэргэшүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, дотоод хяналт, хариуцлагын тогтолцоо бий болгох, төсөв, санхүүгийн асуудал хариуцсан бусад байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах бодлого, зохицуулалтын болон эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Бусад улс орны нийтлэг туршлагад нийцүүлэн, концессын төслүүдийг аль болох "барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх бодлого, зарчмыг баримтлах замаар улсын төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах,
- Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батлахдаа концесс эзэмшигчийг сонгох аргыг хуулиар зөвшөөрөгдсөн нөхцөлтэй уялдуулан тогтоох.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар-т:

- Концессын төслүүдэд гэрээний төлбөр, санхүүжилт олгох хуваарийг улсын төсвийн дунд хугацааны бодлого, төлөвлөлттэй уялдуулж, төсөвт гэнэтийн ачаалал, үр ашиггүй зардал гарах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан-д:

- Хууль, тогтоомжийн дагуу баталж мөрдүүлбэл зохих, шинэчлэн сайжруулах, зохицуулалтгүй орхигдсон үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх болон концессын төслүүдийн хөрөнгө оруулалт нөхөгдөх зохистой хугацаа, төслийн зардал, ашгийг нарийвчлан тооцох, төслийн үйл ажиллагаанд хяналт-үнэлгээ хийх, сонгон шалгаруулалт явуулах журам, аргачлалыг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Концессын гэрээгээр хэрэгжүүлэх шаардлагатай улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан, зардал ашгийн тооцоо, урьдчилсан судалгаа хийгдсэн, хэрэгжүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэгдсэн төслийн жагсаалтыг боловсруулж, Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг шинэчлэн батлуулах,
- Концессын зүйлийн талаар нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг шуурхай хэрэгжүүлэх, арга хэмжээний эдийн засаг, нийгмийн ач холбогдол, үр нөлөөг тооцож ажиллах,
- Концесс зэмших, зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж хэвших,
- Концессын зүйлийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлж байгаа концесс эзэмшигчидтэй эргэн төлөлтийн хуваарийг улсын төсвийн төлөлттэй нийцүүлэх талаар хэлэлцээрт орох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн санал:

ҮАГ-ын санал өгсөн тайлбарыг үзнэ үү.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26 33 33

2018.05.04 № 01/535

танай _____-ны №_____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2018 оны 01/955 дугаар албан тоотоор ирүүлсэн "Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төсөлд холбогдох саналыг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 66 хуудас

ДАРГА Б.БАЯРСАЙХАН

Computer/Disc(D)/Alban bichig/toot A-5 2018/

Саналд өгсөн тайлбар:

Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналыг тайланд хавсралт хэлбэрээр оруулах боломжгүй, ихэнхдээ нотлох баримтын бүрдлийг хангахад чиглэгдсэн байна. Санал хэлбэрээр 14 зүйл ирснээс найруулгын өөрчлөлт хийлгэх 2, хасуулах 12 санал байгаагаас 5 саналыг хүлээн авч хассан, 4 саналыг хэсэгчлэн хүлээн авч найруулгын өөрчлөлт оруулсан бөгөөд доорх 5 саналыг хүлээн авах боломжгүй байна. Үүнд:

Ирүүлсэн санал	Агуулга	Тайлбар
Концессын тухай хуулийн 5.21, 6.28 дугаар зүйлд байвал зохих зохицуулалтын талаар заасан бөгөөд эдгээр журмуудыг тусад нь заавал батлахаар хуульчлаагүй тул тайлангийн 1.2 дахь хэсгийг хасах	Концессын тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих 5 журам, 1 аргачлал боловсруулагдаагүй, хуулийг хэрэгжүүлээгүй.	Журам, аргачлалыг баталж мөрдүүлснээр концессын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зохицуулагдаагүй харилцаа тодорхой болох тул хасах шаардлагагүй.
“Концессын зүйлийн өртөг улсын төсвөөр баригдсан ижил хүчин чадалтай барилга байгууламжийн төсөвт өртгөөс дунджаар 94.8 хувиар өндөр байна” гэснийг бодит байдалтай нийцүүлэн хувь хэмжээг бууруулах	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс санхүүжсэн, 2012-2017 онд барилга угсралтын ажил хийгдсэн ижил хүчин чадалтай барилгын дундаж өртгийг концессын төслийн өртөгтэй харьцуулж үзэхэд ойролцоогоор 42.7-174.2 хувиар өндөр байна.	Харьцуулалтыг хийхдээ хэрэгжиж эхэлсэн болон дуусах хугацаа ойролцоо төслүүдийг сонгон авч тооцоолол хийж, харьцуулалт хийсэн үзүүлэлтийг тайланд тодорхой оруулсан тул хасах шаардлагагүй.
Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолын 2.1-д “Засгийн газраас улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал гэж үзэн тэргүүлэх ач холбогдол өгч байгаа 2020 он хүртэл төсөвт хүндрэл учруулахгүй концессын зарим төслийг “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхэд энэ тогтоолын 1 дүгээр зүйл хамаарахгүй” гэсэн заалтыг Засгийн газрын 2017 оны 16 дугаар тогтоолоор нэмсэн тул хасах	Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолыг зөрчиж, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулсан 686.0 тэрбум төгрөгийн 11 гэрээг цуцлаагүй, концессын “барих-шилжүүлэх” төрлийн 1,050.5 тэрбум төгрөгийн 8 гэрээг шинээр байгуулсан.	Нийт 1.7 их наяд төгрөгийн 19 “барих-шилжүүлэх” гэрээ байгуулснаас зөвхөн шинээр байгуулсан 8 гэрээний хувьд 2019 онд 232.9 сая юань, 37.3 сая ам.долларын эргэн төлөлт хийгдэнэ. Нийтдээ 2018 онд 438.7 тэрбум, 2019 онд 336.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг “барих-шилжүүлэх” төрлийн гэрээгээр хийж, төсөвт үзүүлэх ачаалал өндөр байгаа тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
Засгийн газрын 2017 оны 16 дугаар тогтоолоор нэмсэн дээрхтэй ижил тайлбартай хасуулах саналтай.	Гэтэл Засгийн газар дээрх 37 дугаар тогтоол гарсны дараа эдгээр концессын зүйлд гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрүүдийг Засгийн газрын 2016 оны 148, 213, 264, 317, 2017 оны 107, 113, 120 дугаар тогтоолуудаар гаргаж, өмнөх шийдвэрээ үгүйсгэсэн байна.	Засгийн газрын шийдвэрүүд өөр хоорондоо харилцан уялдаагүй гарсантай холбогдуулан бичсэн тул хасах шаардлагагүй.

Жишээнд дурдсан төслүүдийн гэрээ хүчин төгөлдөр болоогүй байх хугацаанд Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсон, зэрэгцээд Засгийн газрын 37 дугаар тогтоол гарч зогсоосон зэрэг шалтгаанаар барилга угсралтын ажил хойшилсон тул барилгыг хүлээлгэн өгөх хугацааг сунгасан тул хасах	Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцийн өөрчлөлт зэргээс ажил хугацаандаа хийгдэхгүй, гэрээнд сунгалт хийж байгаа нь концессын төслийн үр ашгийг бууруулах хүчин зүйл болж байна.	Төрийн байгууллагуудын тогтвортой бус үйл ажиллагаа төслүүдийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 11 өдөр Дугаар А/140 Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Засгийн Газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /М.Даваанямм/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Khereg\Tushaal\2018\0612GAG1.Docx

070844

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 06 дугаар сарын 11 -ны өдрийн А/140 дугаар тушаалын хавсралт

"КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛИАР ТӨРИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТАД БАТЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД" ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Хариуцах байгууллага	Дугаар		Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/	
		Төлбөрийн акт	Албан шаардлага		Төлбөрийн акт	Албан шаардлага
1	Үндэсний хөгжлийн газрын дарга	01/91		Гэрээнд заасан төлбөрийг хугацаанд нь төлөөгүй	1,454.5	
2	Үндэсний хөгжлийн газрын дарга		01/223	Гэрээнд үнийн дүнг тусгаагүй		
	НИЙТ ДҮН				1,454.5	

Хавсралт №1

ТӨРИЙН ӨМЧИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАГДСАН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

/сая төгрөг/

№	Концессын зүйлийн нэр	Концессын төрөл	Гэрээний	Концесс эзэмшигчийн нэр	Концесс хэрэгжүүлэх хугацаа		Гэрээний		
							Валютын төрөл	Мөнгөн дүн	
			Огноо		Эхлэх	Дуусах		Үндсэн валютаар	Сая төгрөгөөр
Барих-шилжүүлэх" төрлөөр гэрээ байгуулсан									***2,673,106.7***
1	Мандал сум Зүүн Хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төсөл	Барих-шилжүүлэх	2015.03.25	Замын битум ХХК	2015.03.25	2015.09.30	USD	6,473,735.00	13,141.7
2	Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох	Барих-шилжүүлэх	2015.09.25	Маргад Монгол ХХК	2015.09.25	2015.11.30	MNT	400,000,000.00	400.0
3	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл	Барих-шилжүүлэх	2015.06.05	Эрчим хүчний барилга угсралтын трест ХХК	2015.06.05	2017.09.01	USD	76,963,494.00	186,800.4
4	Алтай-Дарви чиглэлийн 98км хатуу хучилттай авто зам төсөл/	Барих-шилжүүлэх	2015.03.25	Лунзянь роуд энд бридж ХК	2015.03.25	2016.07.30	CNY	377,554,752.00	140,291.8
5	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл	Барих-шилжүүлэх	2015.03.13	Лунзянь роуд энд бридж ХК	2015.03.13	2016.07.30	CNY	569,049,587.00	211,447.4
6	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил	Барих-шилжүүлэх	2015.09.25	Хансуун зам ХХК	2015.09.25	2015.12.15	MNT	6,952,033,901.00	6,952.0
7	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил төсөл	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	2016.03.16	ЗМЗ ХХК	2016.03.16	2016.07.30	MNT	1,949,888,978.00	1,949.9
8	Хөвсгөл аймгийн Галт сумын Идэрийн голын хөвдөг гүүрний барилгын ажил төсөл	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	2016.03.28	Урагшлах ХХК	2016.03.28	2016.09.01	MNT	787,500,000.00	787.5
9	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төсөл	Барих-шилжүүлэх	2017.04.12	Шинжиан Шинфа ХХК	2017.04.12	2019.10.30	USD	67,907,000.00	164,819.1
10	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл 11.1. 50 км авто зам 11.2. 50 км авто зам 11.3. 67 км авто зам Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох.	Барих-шилжүүлэх	2017.03.30	Монгол ЛЗ зам гүүр ХХК	2017.03.30	2018.10.31	CNY	660,017,006.00	245,249.1
11	Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22,2 км хатуу хучилттай авто зам	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	2016.07.04	Пик Девеломент ХХК	2017.03.30	2016.12.31	MNT	26,640,000,000.00	26,640.0
12	Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.24	Наранбулаг Хан ХХК	2016.06.24	2016.08.15	MNT	1,761,993,840.00	1,762.0

13	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл 12.1 65.5 км авто зам 12.2 70 км авто зам Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох.	Барих-шилжүүлэх	2017.02.03	Хос мөнгөн зам ХХК	2017.02.03	2017.03.30	USD	86,508,551.00	209,967.5
14	Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл	Барих-шилжүүлэх	2017.03.30	Эн Си Эф ХХК	2017.03.30	2018.10.30	USD	35,922,290.00	87,188.1
15	Дорноговь аймгийн Сайншанд сум болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам төсөл	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	2017.04.12	Засаг Чандмань ХХК	2017.04.12	2019.10.30	MNT	162,869,202,818.00	162,869.2
16	Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) хүртлэх 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминалын хамт барих	Барих-шилжүүлэх	2014.04.04	Кью Эс Си ХХК	2014.04.04	2044.04.04	USD	106,900,000.00	259,460.2
17	Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замгай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих.	Барих-шилжүүлэх	2014.04.04	Кью Эс Си ХХК	2014.04.04	2044.04.04	MNT	81,300,000,000.00	81,300.0
18	Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих төсөл	Барих-шилжүүлэх	2017.04.13	"Томо бюлдинг" ХХК	2017.04.13	2019.08.13	MNT	25,724,600,000.00	25,724.6
19	Нийслэлийн Баянгол дүүрэг, 38 дугаар дунд сургууль төсөл, 960 суудалтай	Зураг төсөл боловсруулах-буулгах-барих-шилжүүлэх	2016.02.05	ӨВМТХ ХХК	2016.02.05	2017.09.01	USD	6,705,790.00	16,275.8
20	Нийслэлийн Баянгол дүүргийн 73 дугаар дунд сургууль төсөл, 920 суудалтай	Зураг төсөл боловсруулах-буулгах-барих-шилжүүлэх	2016.02.05	Монкон констракшн ХХК	2016.02.05	2017.07.31	USD	4,836,919.00	11,739.8
21	Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургууль төсөл, 640 суудалтай	Зураг төсөл боловсруулах-буулгах-барих-шилжүүлэх	2016.05.19	Ганьт ХХК	2016.05.19	2017.08.20	MNT	5,800,000,000.00	5,800.0
22	Баянзүрх дүүрэг, 14-р дунд сургуулийн барилга барих	Буулгах-барих-шилжүүлэх	2016.06.14	Цамхаг констракшн ХХК	2016.06.14	2017.08.01	MNT	10,787,000,000.00	10,787.0
23	Хөвсгөл, Шинэ-Идэр сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.22	Хөвсгөл геологи ХК	2016.06.22	2016.10.10	MNT	2,357,857,567.00	2,357.9
24	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 320 хүүхдийн сургуулийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.22	Хөвсгөл геологи ХК	2016.06.22	2017.10.01	MNT	6,116,389,381.00	6,116.4
25	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.22	Хөвсгөл геологи ХК	2016.06.22	2017.09.25	MNT	2,806,617,681.00	2,806.6
26	Ховд, Жаргалант, 180 ортой 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.24	Улаан дөл ХХК	2016.06.24	2017.06.15	MNT	2,050,346,111.00	2,050.3
27	Дундговь, Сайнцагаан сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.24	Бармон ХХК	2016.06.24	2017.08.30	MNT	3,275,088,590.00	3,275.1

28	Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор сургуулийн хашаанд 100 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.24	Жинсийн орой ХХК	2016.06.24	2016.11.01	MNT	1,386,589,000.00	1,386.6
29	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 6-р цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.04.18	Зүүншанд ХХК	2016.04.18	2016.11.01	MNT	1,154,035,551.00	1,154.0
30	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Баян ойт 1-р цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Зүүншанд ХХК	2016.06.20	2016.11.01	MNT	1,154,035,551.00	1,154.0
31	Баянхонгор аймгийн Богд суманд баригдах 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Жишиг бетон ХХК	2016.06.20	2016.11.01	MNT	738,246,207.00	738.2
32	Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Жишиг бетон ХХК	2016.06.20	2016.11.01	MNT	1,159,677,684.00	1,159.7
33	Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгонд баригдах 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Очир заан ХХК	2016.06.20	2016.11.01	MNT	1,029,917,704.00	1,029.9
34	Хөвсгөл, Жаргалант сум, 150 ортой, цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Хөвсгөл бат чандмань ХХК	2016.06.20	2016.10.30	MNT	2,050,346,111.00	2,050.3
35	Хөвсгөл, Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Идэр чандмань ХХК	2016.06.20	2017.08.30	MNT	3,616,539,040.00	3,616.5
36	Баянхонгор аймгийн Баянговь суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	Бианконэро констракшн ХХК	2016.06.20	2016.11.01	MNT	1,276,775,530.00	1,276.8
37	Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (50км), өргөтгөл, дэд станцын хамт барих.	Барих-шилжүүлэх	2014.04.04	Кью Эс Си ХХК	2014.04.04	2018.04.04	MNT	12,576,200,000.00	12,576.2
38	"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт	Барих-шилжүүлэх	2017.03.30	Алтай трест ХХК	2017.03.30	2018.06.30	USD	31,798,194.00	77,178.4
39	Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажил төсөл	Барих-шилжүүлэх	2015.10.21	Чайна гэжуба групп лимитэд компани	2015.10.21	2017.01.21	USD	98,316,328.00	238,626.5
40	Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл/ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих.	Барих-шилжүүлэх	2017.01.12	Монголын алт ХХК	2017.01.12	2018.02.12	USD	32,231,104.00	78,229.1
41	Сэлэнгэ аймгийн Мандал сумын дулааны төв шугам, дулааны дэд станц, бохирын шугам барих барилгын ажил	Барих-шилжүүлэх	2016.04.22	Бумбод ХХК	2016.04.22	2017.10.01	MNT	18,619,468,425.00	18,619.5
42	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулах төсөл ЗГ-ын 2017.09.20-ны өдрийн 264 дүгээр тогтоолоор "Сургууль, цэцэрлэг барих төсөл" болгон өөрчилсөн.	Барих-шилжүүлэх	2015.02.18	Рич Голден Буллс Эдүкэшн ХХК	2015.02.18	2016	USD	142,700,000.00	346,351.5
Барих-ашиглах шилжүүлэх төрлөөр									***9,953,354.4***
43	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам төсөл	Барих-ашиглах - шилжүүлэх	2011.10.26	Ар Ди Си Си ХХК	2011.10.26	Концессын гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш 17 жил	MNT	109,000,000,000.00	109,000.0

44	Эрдэнэт хотоос Овоотын уурхай чиглэлийн төмөр зам төсөл	Зураг төсөл болоосруулах-барих-ашиглах-шилжүүлэх	2015.08.20	Нортерн Рэйлвэйс ХХК	2015.08.20	Суурь бүтцийг тээврийн үйл ажиллагаа явуулах зорилгоор улсын комисс хүлээн авсан өдрөөс хойш 30 жил	USD	1,300,000,000.00	3,155,269.0
45	Багануурын цахилгаан станц төсөл	Барих-ашиглах-шилжүүлэх	2015.04.01	Багануур Пауэр ХХК	2015.04.01	Барилгын хугацаа болон ашиглалтын хугацааг оруулаад нийт 25 жил	USD	948,100,000.00	2,301,162.0
46	Дулааны Ү цахилгаан станц	Барих-ашиглах-шилжүүлэх	2014.06.20	Фифт Комбайнд Хийт энд Пауэр Плант ХХК	2014.06.20	Станцын үйлдвэрлэл эхлэх өдрөөс хойш 25 жил	USD	1,500,000,000.00	3,640,695.0
47	Тэлмэний дулааны цахилгаан станц	Барих-ашиглах - шилжүүлэх	2013.06.28	Шинэ Азиа групп ХХК	2013.06.28	Концессын гэрээний хугацаа 22 жил	USD	183,390,000.00	445,111.4
48	Увс аймгийн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам барих төсөл	Зураг төсөл боловсруулах-санхүүжүүлэх-барих-ашиглах-шилжүүлэх	2016.03.16	Баруун Монгол Энержи ХХК	2016.03.16	Концессын гэрээний хугацаа 30 жил	USD	119,800,000.00	290,770.2
49	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нийтийн тээврийн авто буудлыг шинэчлэн байгуулах төсөл	Барих-ашиглах-шилжүүлэх	2016.07.18	Ай Эй И ХХК	2016.07.18	Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 25 жил	MNT	11,346,877,400.00	11,346.9
50	Хүний хөгжлийн төв цогцолбор төсөл	Барих-ашиглах - шилжүүлэх	2014.09.18	Жам Зам Инвестмент ХХК	2014.09.18	Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 жил			
51	Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны автозам төсөл	Барих-ашиглах - шилжүүлэх		Чингис Лэнд Девелопмент групп-Шинэ хөгжлийн зам ХХК					
Барих-өмчлөх-ашилах төрлөөр									***3,956,221.9***
52	Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Тэвшийн говийн цахилгаан станц төсөл	Барих-өмчлөх-ашиглах	2017.03.30	"Могул Пауэр" ХХК	2017.03.30	Гэрээний хугацаа гэж арилжаа эхлэх өдрөөс эхлэж 25 жил	USD	1,100,000,000.00	2,669,843.0
53	"Туул-Сонгино" усны нөөцийн цогцолбор	Барих-өмчлөх - ашиглах	2014.04.08	"Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц" ХХК	2014.04.08		USD	350,000,000.00	849,495.5

54	Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл/ Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын барилга барих	Барих-өмчлөх-ашиглах	2015.04.10	Нэйшнл Трэйдинг энд Транспорт Групп ХХК	2015.04.10	Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 жил	USD	55,000,000.00	133,492.2
55	Монгол угсаатны үндэсний музейн цогцолбор байгуулах төсөл	Зураг төсөл боловсруулах-барих-өмчлөх-ашиглах	2015.07.07	Секрет Монголс ХХК	2015.07.07	Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 20 жил	USD	125,000,000.00	303,391.3
Шинэчлэн сайжруулах -барих-ашилах төрлөөр									***700,000.0***
56	Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК-ийн үйл ажиллагаа, хүчин чадлыг жилийн 300 мянган тоннд хүргэх өргөтгөл, техник технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмрийн хүдэр боловсруулж, төмөрлөгийн цогцолбор байгуулж эцсийн бүтээгдэхүүн гаргах; Сэлэнгэ аймгийн Ерөө сумаас Хүдэр сумын Төмөртэй уурхай хүртэл 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (50км), өргөтгөл, дэд станцын хамт барих; Хуст уул, Төмөртолгой, Төмөртэй ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, жилдээ 3.0 саяас доошгүй тонн төмрийн хүдэр олборлох, жилд 1.5 саяас доошгүй тонн төмрийн хүдрийн хуурай болон нойтон аргын баяжмал үйлдвэрлэх үйлдвэр;	Шинэчлэн сайжруулах- барих-ашиглах-шилжүүлэх	2014.04.04	"Кью Эс Си" ХХК	2014.04.04	Концессын гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш 30 жил /Гэрээнд талууд гарын үсэг зурж, энэхүү гэрээний 2.13-т заасан концессын урьдчилгаа төлбөрийг концесс эзэмшигч төлснөөр гэрээ хүчин төгөлдөр болно./	MNT	700,000,000,000.00	700,000.0
Нийлүүлэх-суурилуулах-шилжүүлэх									***2,630.0***
57	Төрийн тусгай хамгаалалтын газарт материал илгүүлэгч төхөөрөмж нийлүүлэх төсөл	Нийлүүлэх-суурилуулах-шилжүүлэх	2016.04.18	Эртний говь ХХК	2016.04.18	2017.08.18	CNY	8,350,857.00	2,630.0
Нийт дүн									**17,285,313.0**

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

Хавсралт №2

КОНЦЕССЫН ЗАРИМ ЗҮЙЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮНИЙН СУДАЛГАА

(сая төгрөг)

№	Концессын зүйлийн нэр	БУА-ын өртөг	Хяналтын зөвлөх үйлчилгээ, захиалагч	Менежментийн зардал	Үйл ажиллагааны зардал	Ашиг	Даатгалын зардал	Хүүгийн зардал	Гэрээний нийт дүн
1	Мандал сум Зүүн Хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төсөл	10,557.3	557.5			1,115.0	35.4	876.4	13,141.7
2	Алтай-Дарви чиглэлийн 98км хатуу хучилттай авто зам төсөл/	92,237.3	4,611.9			12,590.4	3,874.0	26,585.5	139,899.1
3	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл	139,010.0	6,950.5			18,974.9	5,838.4	40,081.7	210,855.6
4	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил	6,449.4						502.6	6,952.0
5	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил төсөл	1,713.1	85.5					151.3	1,949.9
6	Хөвсгөл аймгийн Галт сумын Идэрийн голын хөвдөг гүүрний барилгын ажил төсөл	750.0	37.5						787.5
7	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төсөл	119,542.7	6,291.7			9,498.1	3,145.9	28,312.7	166,791.1
8	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл 11.1. 50 км авто зам 11.2. 50 км авто зам 11.3. 67 км авто зам Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох.	171,971.0	8,598.6			17,154.1	7,222.8	39,616.2	244,562.7
9	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл 12.1 65.5 км авто зам 12.2 70 км авто зам Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох.	159,540.4	7,110.3			16,606.1		29,222.8	212,479.7
10	Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших "Болд Төмөр Ерөө Гол" ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө (Баянгол төмөр зам) хүртлэх 33.4 км 1520 мм царигтай төмөр зам, ачиж буулгах терминалын хамт барих	234,207.6						28,357.0	262,564.6
11	Нийслэлийн Баянгол дүүрэг, 38 дугаар дунд сургууль төсөл, 960 суудалтай	14,095.1						2,375.6	16,470.7
12	Нийслэлийн Баянгол дүүргийн 73 дугаар дунд сургууль төсөл, 920 суудалтай	9,944.0						1,936.3	11,880.3
13	Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургууль төсөл, 640 суудалтай	5,143.9				656.1			5,800.0
14	Баянзүрх дүүрэг, 14-р дунд сургуулийн барилга барих	10,271.7			348.5		166.7		10,787.0
15	Хөвсгөл, Шинэ-Идэр сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	2,039.4		18.5				300.0	2,357.9
16	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 320 хүүхдийн сургуулийн барилга барих төсөл	5,036.9		21.5				1,058.0	6,116.4
17	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	2,348.1		18.5				440.0	2,806.6
18	Ховд, Жаргалант, 180 ортой 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл	1,800.9						304.8	2,105.7
19	Дундговь, Сайнцагаан сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	2,330.4		500.0				444.7	3,275.1
20	Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор сургуулийн хашаанд 100 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	1,251.6		30.0				105.0	1,386.6
21	Хөвсгөл, Жаргалант сум, 150 ортой, цэцэрлэгийн барилга барих төсөл	1,750.3						300.0	2,050.3
22	Хөвсгөл, Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга барих төсөл	2,905.7		58.0				652.8	3,616.5
23	Дархан-Эрдэнэтийн замаас Орхон, Сант сум чиглэлийн 22.2 км авто зам	15,322.2		1,365.7				9,952.1	26,640.0
	ДҮН	1,010,219.1	34,243.5	2,012.2	348.5	76,594.8	20,283.2	211,575.5	1,355,276.8

Жич: Гадаад валютаар гэрээ байгуулагдсан төслүүдийн гэрээний үнийг Монгол банкны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн зарласан ханшаар буюу 1 ам.долларыг 2,427.13₮, БНХАУ-ын 1 юанийг 371.58₮-өөр тооцов.

Хавсралт №3

КОНЦЕССЫН “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” ТӨРЛӨӨР ХЭРЭГЖИЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН СУДАЛГАА
/2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гэрээ байгуулсан			Монгол Улсын 2016-2017 оны Төсвийн тухай хуулиар		
		Огноо	Валютын төрөл	Мөнгөн дүн	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэл 2017.12.31
1	Мандал сум (Зүүн хараа) чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам	2015.03.25	USD	6,473,735	13,141.7	13,141.7	13,141.7
2	Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох төсөл	2015.09.25	MNT	400,000,000	400.0	400.0	400.0
3	Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км даацын хатуу хучилттай авто зам барих төсөл	2014.04.04	USD	106,900,000	95,272.2	57,163.3	57,163.3
4	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам	2015.03.25	CNY	377,554,752	117,042.0	52,304.7	51,738.5
5	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам	2015.03.13	CNY	569,049,587	176,405.4	78,825.3	77,975.7
6	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр сургууль/	2016.06.14	MNT	10,787,000,000	10,787.0	10,787.0	10,762.8
7	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/	2016.02.05	USD	6,705,790	14,884.5	5,581.7	5,581.7
8	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль/	2016.02.05	USD	4,836,919	10,736.3	7,515.4	7,512.7
9	Сургуулийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 32 дугаар сургууль/	2016.05.19	MNT	5,800,000,000	5,800.0	5,800.0	5,800.0
10	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/	2016.06.24	MNT	1,386,589,000	1,386.6	796.4	796.4
11	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/	2016.06.20	MNT	2,050,346,111	2,050.3	2,050.0	2,050.0
12	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	2016.06.22	MNT	2,357,857,567	2,357.9	1,687.9	1,687.9
13	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил	2016.03.16	MNT	1,949,888,978	1,949.9	1,365.0	1,365.0
14	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил	2015.09.25	MNT	6,952,033,901	6,952.0	6,952.0	6,952.0
15	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 6 дүгээр цэцэрлэг/	2016.04.18	MNT	1,154,035,551	1,154.0	1,154.0	1,094.5
16	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, Баян-Ойт 1 дүгээр цэцэрлэг/	2016.06.20	MNT	1,154,035,551	1,154.0	1,154.0	1,136.1
17	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Баянхонгор, Богд сум	2016.06.20	MNT	738,246,207	738.2	738.2	705.4
18	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2016.06.20	MNT	1,029,917,704	1,029.9	1,029.9	995.0
	НИЙТ ДҮН				**463,241.9**	**248,446.5**	**246,858.7**

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар, Сангийн яам

Хавсралт №4

ЗАРИМ УЛС, ОРНЫ ТХХТ-ИЙН ТОГТОЛЦООНД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улс	Эхэлсэн огноо	Давуу тал	Сул тал	Ашиглагдаж буй төрлүүд	Сайн жишээ
БНСУ	1994 оноос дэд бүтцийн салбарт хувийн хөрөнгө оруулалт хийж эхэлсэн, 1999 оноос эрх зүйн орчны шинэчлэлт хийгдсэн.	Эрх зүйн актуудад концессын төрлүүд, худалдан авах арга, үйл явц, зөрчлийг шийдвэрлэх, цуцлах механизм, ТХХ-ийн үүрэг, оролцоо тодорхой тусгагдсан байдаг.	ТХХТ-ийн төслөөр хэрэгжсэн зам ашигласны төлбөр төрийн санхүүжилттэй баригдсан замынхаас 1-3 дахин өндөр байдаг.	Барих-шилжүүлэх-ашиглах, барих-шилжүүлэх-түрээслэх төрлийг тулхүү хэрэглэдэг ба барих-өмчлөх-шилжүүлэх, барих-өмчлөх-ашиглах төрлүүдийг бас ашигладаг.	"Geo-ga" гүүр, Инчоны нисэх онгоцны буудал,
		Олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах Засгийн газрын үүрэг хариуцлагыг гэрээнд зааж өгдөг.			
		Төслийг ТХХТ-ээр хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан тохиолдолд зардал, ашиг, Засгийн газрын дэмжлэг, түншлэлийн загварыг нарийвчлан тооцож, тогтоодог.	Төсөл боловсруулах, өргөн барих өртөг өндөр байдгаас төсөлд санал ирүүлэх оролцогч цөөн байдаг нь төслийн үр ашгийг хязгаарладаг.		
		Засмал зам, далайн боомт, төмөр замын төслүүдийг ихэвчлэн хэрэгжүүлдэг бөгөөд хэрэглэгч төсөл системтэй.			
		Засгийн газрын хүчтэй дэмжлэг, эрх зүйн баталгаатай орчин, мэргэжлийн зөвлөгөө, судалгаа, сургалт сайтай.	Дэлхийн санхүү, эдийн засгийн хямдрал, ханшийн өөрчлөлт, байгалийн гамшиг, байгаль орчинтой холбоотой асуудлуудтай холбоотойгоор зарим төсөл үр дүн багатай хэрэгжих, хүлээсэн үр дүнд хүрэхгүй байх тохиолдол гардаг.		
		Хяналт шалгалт, гэрээний биелэлтэд өгөх үнэлгээ, зөвшилцөл сайн хийгддэг.			
		Төслүүдийн эдийн засгийн үр ашгийг тооцохоос гадна чанарын тухайлбал, эцсийн хэрэглэгчийн сэтгэл ханамж, цаг хугацаа болон санхүүгийн хэмнэлт, хэрэглээний дэвшил зэргийн үр дүнг тооцдог.			
		ТХХТ-ийг дагнан хариуцдаг мэргэжлийн байгууллага, хэрэгжүүлэх тусгай сан байгуулсан.			
Турк	1984 оноос эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн ба 1992 оноос үл ажиллагаа болгосон.	Эрх зүйн орчин бүрдүүлэхэд онцгой анхаарч цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. (1984-1997 онуудад)	Эрх зүйн орчныг шинэчлэх, улам боловсронгуй болгох шаардлагатай болсон.	Барих-ашиглах, барих-ашиглах-шилжүүлэх, барих-түрээслэх-шилжүүлэх	Нисэх онгоцны буудал, усан онгоцны боомт барих төслийг амжилттай хэрэгжүүлсэн.
		Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийг татан оролцуулж чадсанаараа Дэлхийд II байранд ордог. Хувийн хэвшлийн туршлага, ур чадварыг сайн ашигладаг, хувийн хэвшил нь туршлагажсан.	Төрийн байгууллагын хэрэгжилтийн үйл явцад оролцох оролцоо тааруу, зохион байгуулалт муутай.		
		ТХХТ-ийн загварын давуу тал, ОУ-д түгээмэл ашигладаг хэлбэрийг нутагшуулсан.	Хувийн хэвшил санхүүгийн алдагдалд орох тохиолдол гардаг.		
		Төслийн зардал, эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлж чадсан.			
		Төсөлд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ тодорхой байдаг.	Төслүүдийн хэрэгжих хугацаа удаашралтайгаас зардал ихтэй.		
		Үйлчилгээний чанарын түвшнийг анхааран үздэг.	Төрийн хувьд уян хатан бодлого барьдаггүй.		
ОХУ	2009 оноос эхлэн хэрэгжүүлж байна.	ТХХТ-ийн асуудал хариуцсан "Хөрөнгө оруулалтын бодлого, ТХХТ-ийн газар" нь ЭЗХЯ-нд харьяалагдаж, тухайн чиг үүргээ дагнан хэрэгжүүлдэг.	Эрх зүйн орчны шинэчлэлт хийх шаардлагатай.	Барих-ашиглах-шилжүүлэх төрлийг ихэвчлэн ашигладаг.	2009 онд 23 төслийг хэрэгжүүлж эхэлсэн бол 2013 онд 887

		Нийгмийн үйлчилгээний салбарт, тухайлбал, нийгмийн халамж, өндөр настны эмчилгээ, үйлчилгээнд хувийн хэвшлийг түлхүү ашигладаг.			
		ТХХТ-ээр хэрэгжиж буй төслүүдэд иргэдийн зүгээс хяналт тавих боломжийг бий болгох чиглэлээр ажиллаж байгаа.			
ХБНГУ	1925 оноос эхлэл нь тавигдсан.	Төслийг хэрэгжүүлэхээр төрийн албан хаагчид, төрийн нэрийн өмнөөс байгуулагдсан хувийн хэвшил, хувьцаа эзэмшигч бүхий консорциум ажилладаг.	Бие даасан хууль байхгүй	Барих-ашиглах, барих-ашиглах-шилжүүлэх, бариулах-худалдан авах зураг зэрэг олон төрлүүдийг ашиглаж байгаагаас барих-ашиглах төрлийг түлхүү хэрэглэдэг.	Дэд бүтэц, нийтийн хэрэглээ, нийгмийн салбаруудын төслүүдийг түлхүү хэрэглэдэг.
		Хэрэгжүүлж эхлэхээс өмнө төслийн талаар судалгаа хийж, ТЭЗҮ-г боловсруулдаг ба тухайн үйл явцад хийх төрийн хяналт сайн.	Эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлснээр хөрөнгө оруулалт хийх сонирхогчид цөөрсөн.		
		Төсөлд оруулах хөрөнгийн хэмжээ, Засгийн газрын баталгаа, шууд төлбөр зэргийг тодорхой тогтоохоос гадна төслийн үр дүн тодорхой байдаг. Мөн төрийн өмчийг ашиглах, зарж борлуулах үйл ажиллагааны хязгаарыг тогтоож өгсөн байдаг.	Төр эдийн засгийн хувьд хувийн хэвшлээс хамааралтай болох магадлалтай.		
		Гэрээ байгуулахаас өмнө төслийн гүйцэтгэлтэй холбоотой шалгуур үзүүлэлт, гэрээний загварыг боловсруулж, төрийн зүгээс хяналт тавих түвшнийг, гэрээлэгч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгаж өгдөг.	ТХХТ-ийн гэрээ олон нийтэд нээлттэй бус байгаагаас олон нийт хяналт тавих боломжгүй, мэдээлэл хомс байдгаас олон нийтийн ойлголт дутуу.		
		Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг олон нийтэд зарлаж, зөвхөн шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулдаг.	Төсвөөс төлөх өрийн дарамт үүсэх магадлалтай.		
		Эргэн төлөлтийг тогтвортой хийдэг байдал нь хувийн хэвшлийг татдаг.			
Англи	1989 оноос бодлогын баримт бичиг баталгаажаж, 1990 оноос ашиглаж эхэлсэн.	Төслийн эргэн төлөлтийг урт хугацааны туршид буюу 20-35 жилийн хугацаанд гэрээ заасны дагуу төлдөг.	Хувийн хэвшил төслийн санхүүгийн, техникийн, үйл ажиллагааны эрсдэл хүлээдэг.	Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилга гэсэн төрлийг түлхүү ашигладаг. Энэ барих-ашиглах-шилжүүлэх төрөлтэй хэлбэрийн хувьд төстэй.	Эрүүл мэнд, батлан хамгаалах, боловсролын салбарын төслүүдийг түлхүү хэрэгжүүлдэг.
		Концесс хариуцсан нэгж нь Сангийн яамандаа харьяалагддаг.	Төслийг сонгон шалгаруулах үйл явц хугацаа их шаардаг нь хувийн хэвшлийн хувьд өртгийг нэмэгдүүлж, төслийн үнэ цэнийг бууруулдаг.		
		Мэдээллийг нээлттэй тараадаг. Нэг ижил мэдээллийг нэг ижил хугацаанд сонирхогч тал хүлээн авах боломжтой.			
		Зардал, ашгийн тооцооллыг зөв хийх нь төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх алхам болдог учраас тооцооллыг хийхдээ тоон судалгаанаас гадна чанарын судалгааг давхар хийж, төслийн хэрэгжилтийн үед тулгарч болох эрсдэлийн шинжилгээг системтэй, дэс дараалалтай хийж, түүндээ ач холбогдол өгдөг.	Төслийн ирээдүйн үр ашгийн талаарх мэдээлэл хангалттай, ил тод байдаггүй.		
			Төрийн зүгээс төслийг хэрэгжүүлэхэд уян хатан бодлого барьдаггүй.		
		ТХХТ нь Засгийн газрын өрийг бууруулахад онцгой үүрэг гүйцэтгэсэн.	ТХХТ-ийн харилцааг зохицуулсан тухайлсан хууль байхгүй.		

Эх сурвалж:"Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сорилт, боломж" судалгааны тайлан, 2017 он, Удирдлагын академи